

# ҮГ ХЭЛЭХ, ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Эрх зүйн орчны үнэлгээ

## **ҮГ ХЭЛЭХ, ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ**

### **Эрх зүйн орчны үнэлгээ**

Энэхүү үнэлгээг Хэвлэлийн Хүрээлэнгээс Ашгийн бус хуулийн олон улсын төвийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Монгол дахь үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрх зүйн орчныг сайжруулах нь” төслийн хүрээнд хэрэгжүүлэв.

Үнэлгээг хэрэгжүүлсэн судлаачдын баг

Г.Балжмаа

Л.Галбаатар

Д.Оросоо

Зөвлөх: М.Мөнхмандах, Ph.D

Зохицуулагч: Ч.Байгалмаа

Хэвлэлийн Хүрээлэн

Их Тойруу 54, Сүхбаатар дүүрэг

Улаанбаатар хот

2022 он

---

АГУУЛГА

АГУУЛГА .....	3
<b>УДИРТГАЛ .....</b>	<b>4</b>
<b>A. ЕРӨНХИЙ ЗАРЧИМ.....</b>	<b>5</b>
<b>B. МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ.....</b>	<b>9</b>
<b>C. ҮГ ХЭЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХЯЗГААР.....</b>	<b>21</b>
<b>D. ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ ГҮТГЭЛЭГ .....</b>	<b>24</b>
<b>E. ОНЛАЙН КОНТЕНТЫН ЗОХИЦУУЛАЛТ .....</b>	<b>26</b>
<b>F. МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ БА ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ .....</b>	<b>30</b>
<b>G. ИНТЕРНЭТТЭЙ БАЙХ ЭРХ.....</b>	<b>36</b>
<b>H. ХУВИЙН ХАЛДАШГҮЙ БАЙХ ЭРХ: МӨРДӨН МӨШГӨХӨӨС АНГИД БАЙХ.....</b>	<b>40</b>
<b>Тийм .....</b>	<b>46</b>
<b>I. ХУВИЙН ӨГӨГДӨЛ ХАМГААЛАХ .....</b>	<b>47</b>

## **УДИРТГАЛ**

Энэхүү үнэлгээг Хэвлэлийн Хүрээлэнгээс Ашгийн бус хуулийн олон улсын төвийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Монгол дахь үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрх зүйн орчныг сайжруулах нь” төслийн хүрээнд хэрэгжүүлэв. Үнэлгээг хийхдээ Ашгийн бус хуулийн олон улсын төвөөс эрхлэн гаргасан Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө. Хууль тогтоогч, эрх зүйн шинэчлэлийг дэмжигчдэд зориулсан гарын авлагыг Монгол хэлнээ хөрвүүлэн ашигласан болно. Уг гарын авлагад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зөрчиж болзошгүй хууль тогтоомж, тодорхой заалт, зохицуулалтыг шинэчлэхэд жишиг болгон ашиглахад зориулж холбогдох шилдэг туршлагыг товч танилцуулсан байдаг. Гарын авлагад орсон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хүрээнд тодорхой сэдэвтэй холбоотой олон улсын хууль эрх зүйн стандарт, шилдэг туршлагыг Монголын нөхцөл байдалтай харьцуулж, үнэлэв.

Үнэлгээний хүснэгтийн эхний баганад тухайн асуудалтай холбоотой шалгуур үзүүлэлт, хоёр дах баганад шалгуурыг хангаж буй эсэх, дараагийн баганад олон улсын нийтлэг хэм хэмжээ, төгсгөлийн баганад Монголын нөхцөл байдлыг товч тайлбарласан болно.

## А. ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

### Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө

№	Асуулт	Хариулт	Олон улсын болон бүс нутгийн хэм хэмжээний шилдэг туршлага, зөвлөгөө	Монгол Улсын нөхцөл байдал
A1.	Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг арьсны өнгө, хүйс, хэл, үндэс угсаа, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, улс төрийн харьяалал, үндэс угсаа, нийгмийн гарал үүсэл, нас, нийгмийн анги давхарга, боловсролын түвшин, ажил мэргэжил, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, хүйс таних тэмдэг эсвэл бусад нөхцөл байдалд хамаатуулан хуулиар хязгаарласан уу?	Үгүй	Хүн бүр тодорхой шинж чанар, бусдын үнэлэмжээс үл хамааран үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй.  ИБУТЭТОУП 19(2)-р зүйл, Африкийн Хүний болон Ард түмний эрхийн тунхаглалд 9-р зүйл.	Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, 2-д “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” гэж заасан.
A2	Хэрэв үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хуулиар хамгаалсан бол, энэхүү зохицуулалт нь онлайн болон офлайн орчны аль алинд хамаарч байгаа юу?	Үгүй	Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх зүйн хамгаалалт нь онлайн болон офлайн орчинд хамаарна гэдгийг хуульд тодорхой зааж өгөх ёстой.  U.N.DOC. A/66/290, 14-р догол мөр	Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг Үндсэн хууль болон бусад хуулиар зохицуулдаг, гэвч үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө нь онлайн болон офлайн орчны аль алинд хамаарна гэж тусгайлан зохицуулсан зохицуулалт байхгүй байна.

<p>АЗ</p>	<p>Иргэний нийгмийн төлөөлөгчдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хуулиар тусгайлан хязгаарладаг уу ?</p>	<p>Үгүй</p>	<p>Хүний эрхийн хамгаалагч, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд, иргэний нийгмийн төлөөллийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах нэмэлт зохицуулалт хийх ёсгүй.</p> <p>OC. A/HRC/14/23, D U.N. DOC. A/HRC/20/17; UN.DOC.A/HRC/11/4</p>	<p>Хэдийгээр хууль эрх зүйн зохицуулалтаар иргэний нийгмийн төлөөлөгч, хүний эрхийг хамгаалагчдын үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг тусгайлан хязгаарлаагүй ч хууль тогтоомжийн тодорхой бус байдал, эрх зүйн хийдэл хязгаарлалтыг бий болгож байна.</p> <p>Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд Хүний эрх хамгаалагчид хориглох зүйлд “тайван бус аргаар үйл ажиллагаа явуулах, явуулахыг уриалах, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах” гэж заасан. Хүний нэр төрийг гутаах гэдэг нь хэт ерөнхий ойлголт бөгөөд хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаатай холбогдуулан бусад хуулиар нэгэнт зохицуулсан асуудлыг уг хуульд тусгайлан нэмэлтээр оруулж хуульчлах шаардлага байгаагүй болно.</p> <p>Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар жагсаал, цуглаан хийх тохиолдолд урьдчилан мэдэгдэж бүртгүүлэх шаардлага тавьдаг бөгөөд бүртгүүлээгүй бол бүртгэлгүй жагсаал, цуглаан хийсэн зөрчил гаргасан гэж Зөрчлийн тухай</p>
-----------	---	-------------	---	---

				хуульд зааснаар хариуцлага хүлээх зайлшгүй шаардлагатай бус хуулийн зохицуулалт үйлчилж байгаа нь иргэний нийгмийн зүгээс үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэхэд хүндрэл үүсгэж байна.
A4	Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан хуулийн заалт нь хүн бүхэнд ойлгомжтой томъёологдсон уу?	Тийм →	Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг зөвхөн хуулиар хязгаарлана. Өөрөөр хэлбэл хязгаарласан зохицуулалтыг хуульчилсан байх ёстой бөгөөд тэрхүү хязгаарлалтыг энгийн ойлгомжтой томъёолсон байх, ямар үйлдлийг хориглож буй нь уншиж буй хүнд ойлгомжтой байх ёстой.	Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 3-д “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.” гэж заасан. Хуулиар ямар үйлдлийг хориглож буйг энгийн ойлгомжтой байдлаар тодорхойлсон байдаг. Тухайлбал, үзэл бодлоо илэрхийлэх эрхээ хэтрүүлэхтэй холбоотой гардаг эрх зүйн зөрчилд хамаарах Эрүүгийн хуульд заасан хориглосон зохицуулалт нь ойлгомжтой томъёологдсон байдаг.
A5	Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хуулиар хязгаарласан тохиолдолд тэрхүү хязгаарлалт нь дараах зорилгыг хэрэгжүүлэхтэй холбоотой болохыг тодорхой тайлбарласан уу? Бусдын нэр төр, алдах хүндийг хамгаалах Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хамгаалах Нийтийн эрүүл мэнд, ёс журмыг	Зарим талаар	Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалтыг дараах зорилгуудын дор хаяж аль нэгтэй холбож тайлбарласан байна. - Бусдын нэр төр, алдар хүндийг хамгаалах - Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хамгаалах - Нийтийн эрүүл мэнд, ёс журмыг	Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалтыг Үндсэн хуульд зааснаар дараах зорилгоор хязгаарлах талаар заасан. Үүнд: <ol style="list-style-type: none"><li>1. Үндэсний аюулгүй байдал;</li><li>2. Бусад хүний эрх, эрх чөлөө;</li><li>3. Нийгмийн хэв журам;</li><li>4. Хүний нэр төр, алдар хүндийг</li></ol>

	хамгаалах		хамгаалах ИБУТЭТОУП-ын 19.3	хамгаалах. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарласан тухайн хуулийн хязгаарласан зүйл, заалтад ямар зорилгоор уг эрхийг хязгаарлаж байгааг нарийвчлан тодорхойлж зааж өгдөггүй, харин хуулийн зорилгод тухайн хууль хүний эрхийг хамгаалах, нийгмийн хэм журам хангах, Үндэсний аюулгүй байдлыг хангах зорилготой гэх зэргээр хязгаарлах зорилготой ерөнхий байдлаар холбож тусгасан байгаа нь хэт ерөнхий болж, тодорхой бус байдлыг болгож байна.
А6	<p>Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалт бүрийг Асуулт 5-д тодорхойлсон зорилгод нийцэх хамгийн бага хэмжээгээр тогтоосон уу?</p> <p>АНХААР: Асуулт 5-д тодорхойлсон зорилгуудын хүрээнд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалтыг багасгах өөр арга зам бий ?</p>	Үгүй	<p>Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалт нь “зайлшгүй шаардлагатай” байна. Өөрөөр хэлбэл Асуулт 5-д тодорхойлсон зорилгод хүрэхэд шаардлагатай хамгийн бага хэмжээний хязгаарлалт байх ёстой.</p> <p>ИБУТЭТОУП-ын 19.3</p>	<p>Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалт нь хуулиар тогтоосон зорилгод хүрэхэд зайлшгүй байх шаардлагатай явдал юм. Хязгаарлалт нь эдгээр зорилгод хүрэхэд хамгийн бага хэмжээгээр тогтоосон байх ёстой. Гэтэл манай хууль тогтоомжийн хязгаарлалт нь зайлшгүй байх, хүний үндсэн эрхийг хамгийн бага хэмжээгээр хязгаарлах шаардлагыг бүрэн хангахгүй байна.</p> <p>Үүний нэг жишээ бол Зөрчлийн тухай хуульд зааснаар Бүртгэлгүй жагсаал, цуглаан хийсэн бол зөрчилд тооцож хууль зүйн</p>



				<p>хариуцлага хүлээлгэж байгаа явдал, жагсаал, цуглаан хийхэд заавал бүртгүүлэх буюу зөвшөөрөл авч байгаа нь үндсэн эрхийг хөндөж байгаа буюу зайлшгүй шаардлагатай хязгаарлалт биш, хамгийн бага хэмжээнд хязгаарлалт хийх шаардлагыг хангахгүй байгаа болно.</p> <p>Тодорхойлсон зорилгуудын хүрээнд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалтыг багасгах боломжтой.</p>
--	--	--	--	---

## В. МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ

№	Асуулт	Хариулт	Олон улсын болон бүс нутгийн хэм хэмжээний шилдэг туршлага, зөвлөгөө	Монгол Улсын нөхцөл байдал
---	--------	---------	--	----------------------------

B1	Хүн бүрийн мэдээлэл авах эрх чөлөөг хуулиар баталгаажуулсан уу (Иргэний биш, хүн бүрийн)	Зарим талаар	Хүн бүр мэдээлэл авах эрхтэй <b>АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ</b> 26(1)(a) and (b).	<p>Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17-д Монгол Улсын <b>иргэн</b> “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” гэж заасан.</p> <p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн зорилгыг <b>хүний</b> мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах гэж тодорхойлсон байдаг. Харин уг хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Хүн, хуулийн этгээд мэдээллийг хүсэлт гаргаж, эсхүл цахим хэлбэрээр, нээлттэй, ил тод байршуулсан мэдээллийг хүсэлт гаргалгүйгээр тухайн цахим хуудсанд хандаж авч болно.”, 7 дугаар зүйлийн 7.7-д “Нийтийн мэдээллийг ашиглахад хуульд зааснаас бусад тохиолдолд <b>иргэний</b> мэдээлэл авах эрх, эрх чөлөөг үл хязгаарлах, төрийн байгууллагын үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй байх, хүн, хуулийн этгээд хуулиар хязгаарлалт тогтоогоогүй аливаа мэдээллийг саадгүй олж авах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.”, 17.2-д “Мэдээлэл хариуцагч хүн, хуулийн этгээд мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулахыг хориглоно.” гэж заасан.</p> <p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар хүн бүр мэдээлэл авах эрхтэй гэж заасан байна</p>
B2	Хуулиар төрийн байгууллага болон дараах төрлийн хувийн хэвшлийн байгууллагаас мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан уу (1) төрийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэдэг хувийн байгууллага (2) улсын төсвөөс санхүүжилт авдаг хувийн байгууллага?	Тийм	<p>Хүн бүр төрийн болон холбогдох хувийн байгууллагаас мэдээлэл авах эрхтэй.</p> <p>Холбогдох хувийн байгууллага гэдэгт бүхлээр болон тодорхой хэсэг нь төрийн өмчлөлд, эсхүл төрийн хяналтад байдаг, эсхүл шууд болон шууд бусаар улсын төсвөөс санхүүждэг, хууль тогтоомжийн дагуу төрийн чиг</p>	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд нийтийн мэдээлэл хариуцагч байгууллагыг дор дурдсан байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:</p> <p>6.1.1. Төрийн байгууллага;</p> <p>6.1.2. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд;</p> <p>6.1.3. Хууль, эсхүл гэрээний үндсэн дээр төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа</p>

			<p>үүрэг, төрийн үйлчилгээ эрхэлдэг байгууллага хамаарна.</p> <p>АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 26(1)(a) болон (b), 26(2)</p>	<p>этгээд;</p> <p>6.1.4. Олон нийтийн радио, телевиз;</p> <p>6.1.5. Улс төрийн нам.</p> <p>Хуулийн 6.1.3-д заасан “хууль, эсхүл гэрээний үндсэн дээр төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа этгээд” гэдэгт (1) төрийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэдэг хувийн байгууллага (2) улсын төсвөөс санхүүжилт авдаг хувийн байгууллагыг хамруулан ойлгож болно.</p>
ВЗ	<p>Төрийн болон олон нийтийн чиг үүрэг бүхий хувийн хэвшлийн байгууллагууд мэдээллийг хэрхэн бэлтгэх, хадгалах, зохион байгуулах, архивлахыг хуулиар зохицуулсан уу?</p>	Тийм	<p>Төрийн болон холбогдох хувийн хэвшлийн байгууллагууд мэдээлэл олж авах эрхийг хэрэгжүүлэхэд түс дөхөм болохуйц байдлаар мэдээллийг хадгалах, зохион байгуулах, архивлах үүрэгтэй. Төрийн болон холбогдох хувийн хэвшлийн байгууллагууд мэдээлэл хадгалах хугацаа, хэлбэрийг хуулиар тодорхой зааж өгч болно.</p> <p>АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ</p>	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд зааснаар мэдээлэл хариуцагч нь мэдээллийг боловсруулах, ашиглах, цуглуулах, нийтийн мэдээллийн дэд бүтэц, нийтийн мэдээлэлтэй холбоотой харилцааг зохицуулсан байна.<sup>1</sup></p> <p>Архив, албан хэргийн хөтлөлтийн тухай хуулиар Монгол Улс дахь үндэсний архивын сан хөмрөгийн баримтыг бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах, хяналт тавих, ашиглах болон албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахаар заасан.</p>

<sup>1</sup> Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.16-д “Энэ хуулийн 8.8-д заасан цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журмыг Засгийн газар батална.”, 8.17-д “Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий, Авлигатай тэмцэх газар, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн бүс байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бүс зөвлөл хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана.”, 8.18-д “Энэ хуулийн 8.17-д заасан зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн болон цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”, 8.19-д “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журмыг Засгийн газар батална.” гэж заасан.

			30.	
B4	Олон нийтийн ашиг сонирхолд онцгой чухал мэдээллийг хэвлэн нийтлэх, олон нийтэд түгээхийг төрийн байгууллагуудад хуулиар үүрэг болгосон уу ?	Тийм	<p>Төрийн болон холбогдох хувийн хэвшлийн байгууллагууд иргэдээс хүсэлт гаргаагүй байсан ч олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн мэдээллийг өөрийн санаачилгаар боломжтой бүх хэрэгслээр идэвхтэй нийтлэх ёстой.</p> <p>АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 29. Түүнчлэн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхийн талаарх баримтын цуглуулгыг үзнэ ҮҮ.</p>	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар мэдээлэл хариуцагч нь олон нийтийн ашиг сонирхолд онцгой чухал мэдээллийг хэвлэн нийтлэх, ил тод байлгах, түгээхтэй холбоотой харилцааг хуулиар зохицуулсан байдаг. Тухайлбал, хуулийн 8.1 дүгээр зүйлд “Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана.” хэмээн тодорхойлоод, эдгээр мэдээллийг мэдээлэл хариуцагчид өөрийн санаачилгаар ил тод болгох буюу цахим талбарт нийтлэхийг үүрэг болгосон.
B5	Засгийн эрх бүхий байгууллагуудын хуралдаан нийтэд нээлттэй хийх тухай хуульд заасан уу?	Зарим талаар	<p>Засгийн эрх бүхий байгууллагуудын хуралдаан олон нийтэд нээлттэй байх зарчмыг хуулиар тогтоосон байх ёстой. Энэхүү зарчмыг ямар нөхцөлд хязгаарлаж болох тухай энэхүү хяналтын хуудаст тусгасан болно.</p> <p>“Засгийн эрх бүхий байгууллага” гэдэгт үндэсний болон орон нутгийн засаг,</p>	Засгийн эрх бүхий байгууллагуудын хуралдаан олон нийтэд нээлттэй байх зарчмыг хуулиар тогтоосон байх олон улсын зарчим манай улсад бүрэн хэрэгжээгүй байна. Засгийн газрын хуралдаан нээлттэй байх асуудлыг харьцангуй сайн зохицуулсан боловч бусад төрийн эрх бүхий байгууллагуудад уг зарчим үйлчлэхгүй байна. Тухайлбал, Засгийн газрын хуралдаан нийтэд нээлттэй байх, хурлыг нээлттэй хийх эсэх асуудлыг Засгийн газрын тухай хууль <sup>2</sup> , Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 351 дүгээр тогтоолоор батлагдсан

<sup>2</sup> <https://legalinfo.mn/mn/detail/344>

			<p>захиргааны түвшинд шийдвэр гаргах эрх мэдэл бүхий байгууллага, агентлаг, хороо болон эрх мэдэл бүхий бусад бүлгийг багтаана.</p> <p>Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхийн талаарх <a href="#">баримтын цуглуулгыг үзнэ үү</a>.</p>	<p>Засгийн газрын хуралдааны журамд<sup>3</sup> заасан байдаг.</p> <p>Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 4-д “Хуралдааныг Ерөнхий сайдын шийдвэрлэснээр нээлттэй буюу хаалттай явуулж болох бөгөөд хуулиар хамгаалсан нууцад хамаарахаас бусад шийдвэрийг олон нийтэд мэдээлнэ.” гэж, мөн зүйлийн 3-д “Засгийн газрын хуралдааны нарийвчилсан дэгийг энэ хуулийн дагуу Засгийн газар тогтооно.” гэсэн байна. Засгийн газрын тухай хуульд засгийн газрын хуралдааныг нээлттэй, эсхүл хаалттай явуулах эсэхийг Ерөнхий сайд дангаараа шийдвэрлэхээр заасан.</p> <p>Засгийн газрын агентлагийн тухай хуулиар 4.1-д “Агентлаг нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмаас гадна төрийн үйлчилгээг жигд, чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, <b>ил тод</b>, мэргэшсэн байх, хууль ёсыг сахих, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх зарчмыг баримтлан ажиллана.” гэж заасан.</p> <p>Засгийн газрын Агентлагийн тухай хуулийн 14.2-д “Агентлагийн удирдлага, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга эрхлэх асуудлаараа албан ёсны мэдээлэл хийхдээ Засгийн газар, Монгол Улсын сайдын бодлогыг баримтална.” гэж заасан. Харин уг хуулиар хуралдааныг олон нийтэд нээлттэй байх асуудлыг тусгаагүй байна, цаашид агентлагийн хуралдааныг олон нийтэд нээлттэй байлгах асуудлаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг</p>
--	--	--	--	---

<sup>3</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389839732841&showType=1>

				дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар нэгж дэх төрийн удирдлагын байгууллагын хуралдааныг олон нийтэд нээлттэй хийх талаар тусаагүй байна.
В6	Мэдээллийг нийтэд ил болгох нь олон нийтийн эрх ашигт сөрөг нөлөөтэй байх цөөн тохиолдлоос бусад нөхцөлд төрийн мэдэлд буй бүх мэдээллийг ил тод байлгахыг хуульчилсан уу?	Үгүй	<p>Мэдээллийн ил тод байдлын хангах хууль нь дээд зэргийн ил тод байдлын хэм хэмжээг удирдлага болгоно. Мэдээлэл авах эрхийг зөвхөн хуулиар нарийвчлан заасан цөөн нөхцөлд хязгаарлах бөгөөд тэдгээр хязгаарлалтыг хуульд тодорхой тайлбарласан байх буюу олон улсын хүний эрхийн хэм хэмжээг дагаж мөрдсөн байна.</p> <p>Мэдээлэл авах эрхийг хязгаарлах тохиолдлын жишээ дурдвал, тухайн мэдээллийг нийтэд ил болгосноор хувь хүний эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал эрсдэл учрах, эсвэл хувь хүний мэдээллийг гуравдагч этгээдэд шаардагдах хэмжээнээс хэтрүүлэн ил болгох эрсдэл зэрэг байж болно.</p> <p>АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 28. Мэдээллийн ил тод байдлыг хязгаарлахыг зөвшөөрөх бүрэн жагсаалтыг АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 33-аас</p>	<p>Мэдээллийн ил тод байдлын хангах хууль нь дээд зэргийн ил тод байдлын хэм хэмжээг удирдлага болгох, Мэдээлэл авах эрхийг зөвхөн хуулиар нарийвчлан заасан цөөн нөхцөлд хязгаарлах бөгөөд тэдгээр хязгаарлалтыг хуульд тодорхой тайлбарласан байх буюу олон улсын хэм хэмжээ хангагдахгүй байна. Тухайлбал 2016 онд баталсан Төрийн болон албаны нууцын тухай хуульд “төрийн нууц”-ын ангиллын хүрээг хэт өргөнөөр тодорхойлсноос гадна “албаны нууц” хэмээх ангиллыг бий болгож, энэхүү ангилалд хамаарах мэдээллийн "тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батлахаар зохицуулсан. Үүний зэрэгцээ .Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд мэдээллийг нээлттэй, хязгаарлалтай, хаалттай хэмээн ангилж, “албаны” нууцын ангилалтай давхардуулан иргэдийн мэдээлэл авахын эрхийг хязгаарласан.</p>

			үзнэ үү	
B7	Төрийн болон холбогдох хувийн байгууллагаас мэдээлэл авахад зөвхөн тухайн мэдээллийг тодорхой хэлбэрээр бэлтгэхэд шаардагдах зардалтай тэнцэх хураамж авахыг зөвшөөрөх тухай хуульд заасан уу (Жишээлбэл мэдээллийг цахимаар илгээх бус, хэвлэж илгээх шаардлагатай бол хэвлэх зардлыг мэдээлэл хүсэгчээс авч болох тухай)	Тийм	Тухайн мэдээллийг хуулбарлахад шаардлагатай зардлаас хэтэрсэн хэмжээний хураамж шаардах ёсгүй. Мэдээлэл хүсэгч төлбөрийн чадваргүй байх тохиолдолд төлбөрөөс чөлөөлнө.  АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 31(4).	Мэдээлэл авахад зөвхөн тухайн мэдээллийг өгөхтэй холбоотой гарсан зардлыг төлөх талаар хуульд заасан байдаг. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд мэдээлэл өгөх үйлчилгээний зардлын талаар зохицуулсан байна. <sup>4</sup>
B8	Мэдээлэл хүсэж буй иргэдээс тухайн мэдээллийг хүсэх болсон үндэслэлээ тайлбарлахыг хуулиар шаарддаг уу ?	Зарим талаар	Мэдээлэл хүсэж буй хүн тухайн мэдээллийг хүсэх болсон шаардлага, шалтгаанаа тайлбарлах, үндэслэх ёсгүй.  АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 31(2).	Мэдээлэл хүсэж буй иргэн нь тухайн мэдээллийг хүсэх болсон үндэслэлээ тайлбарлах асуудал нь зөвхөн хязгаарлалттай мэдээлэл авахад хамаарч байгаа бөгөөд нээлттэй мэдээлэл авахад үндэслэлээ тайлбарлах үүрэг хүлээгээгүй байна. Тухайлбал, хуулийн 13.4.3-д “Хязгаарлалттай мэдээлэл авах бол мэдээлэл авах зорилго, мэдээллийн эзний зөвшөөрөл”-ийг мэдээлэл авах хүсэлтэд тусгах тухай заасан.

<sup>4</sup> [16 дугаар зүйл. Мэдээлэл өгөх үйлчилгээний зардал](#)

16.1. Хүн, хуулийн этгээд цаасан хэлбэрээр мэдээлэл авахдаа хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл өгөхтэй холбогдон гарсан зардлыг төлнө.

16.2. Энэ хуулийн 16.1-д заасан зардал нь уг мэдээллийг өгөхтэй холбогдон гарах хувилах, шуудангаар хүргүүлэх зэрэг шууд зардлаас ихгүй байна.

16.3. Хуульд өөрөөр заагаагүй бол хүн, хуулийн этгээд цахим хэлбэрээр мэдээлэл авахад энэ хуулийн 16.1-д заасан зардлыг төлөх үүрэг хүлээхгүй.

16.4. Энэ хуулийн 16.1-д заасан зардлын хэмжээг энэ хуульд заасны дагуу мэдээлэл хариуцагч тогтоох бөгөөд зардал тооцох аргачлал, зардлыг ТӨЛӨХ, ТҮҮНЭЭС ХӨНГӨЛӨХ, чөлөөлөх журмыг Засгийн газар батална.

16.5. Энэ хуулийн 16.1-д заасан зардлыг хууль тогтоомжид заасан бусад төлбөр, хураамжтай давхардуулан авахгүй.

B9	Мэдээлэл өгөхөөс татгалзаж болох шалтгааныг хуулиар нарийн тодорхойлсон уу ?	Зарим талаар	<p>Мэдээлэл авах эрх чөлөөний хязгаарлалтыг хуулиар нарийн тодорхойлж өгөх ёстой.</p> <p>Мэдээлэл авах эрх чөлөөг хязгаарлаж болох зарим жишээ: Мэдээллийг задруулах нь холбогдох оролцогч талууд болон гуравдагч этгээдийн хууль ёсны арилжааны болон санхүүгийн ашиг сонирхолд ноцтой хохирол учруулах, эсвэл эмч ба өвчтөн, хуульч ба үйлчлүүлэгч, сэтгүүлч ба эх сурвалжийн хоорондын нууц харилцааг задруулахад хүргэх, эсхүл хуулийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил болгох замаар давуу эрх үүсгэх зэрэг байж болно.</p> <p>Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхийн талаарх <a href="#">баримтын цуглуулгыг үзнэ үү</a></p> <p>Мэдээллийн ил тод байдлыг хязгаарлахыг зөвшөөрөх бүрэн жагсаалтыг АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 33-аас үзнэ үү.</p>	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээлэл хариуцагч “нээлттэй” хэмээн тодорхойлсон мэдээллийг өгөх эрхтэй бөгөөд ийм төрлийн мэдээлэл авах хүсэлт нь хуулийн 13 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй, эсхүл үрд өмнө нь хариу өгсөн асуудлаар дахин хандсан, эсхүл хүсэлтэд дурдсан мэдээлэл байхгүй бөгөөд хүсэлтийг холбогдох байгууллагад шилжүүлэх боломжгүй бол уг хүсэлтийг буцаах үндэслэл, журмыг заасан байдаг. Түүнчлэн уг хуулийн дагуу “хаалттай” байхаар хуульчилсан, <b>эсхүл төрийн нууцад хамаарах мэдээллийг хаалттай мэдээлэл</b> авахад, мөн “Танилцах, ашиглахад хуулиар хязгаарлалт тогтоосон албаны нууц болон хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг хязгаарлалттай мэдээлэл” хэмээн үзэж, зөвхөн хуульд заасан нөхцөл, болзлын дагуу авах боломжтой. Жишээлбэл хуулийн 9.2.1 – 9.2.3-д хязгаарлалттай мэдээлэлд “гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад цуглуулсан мэдээлэл; төрийн хяналт шалгалтын явцад болон шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд цуглуулсан мэдээлэл; .нээлттэй байлгах нь соёлын хосгүй үнэт өвд аюул учруулж болзошгүй мэдээлэл” хамаарч байхаар заасан бөгөөд ийм төрлийн мэдээлэл авахад бичгээр хүсэлт гаргаагүй, мэдээлэл эзэмшигчээс зөвшөөрөл аваагүй бол мэдээлэл өгөхөөс татгалзах боломжтой.</p> <p>Харин мэдээлэл авах эрх чөлөөний хязгаарлалтыг хуулиар нарийн тодорхойлж өгөх шаардлагыг бүрэн хангаагүй, мэдээлэл авах эрх чөлөөг хязгаарлаж болох үндэслэлийг тайлбарлаагүй байна.</p>
B10	Мэдээлэл өгөхөөс татгалзсан шалтгааныг ойлгомжтой	Зарим талаар	Мэдээлэл өгөхөөс татгалзсан	Мэдээлэл авах хүсэлтэд татгалзсан хариу өгөх тохиолдолд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 15.2.4-ын дагуу



	тайлбарлах тухай хуульд заасан уу?		<p>тохиолдолд хариуг цаг тухайд нь бичгээр өгнө.</p> <p>Нигерийн Холбооны дээд шүүхээс төрийн байгууллагууд мэдээлэл авах хүсэлт гаргаснаас хойш 7 хоногийн дотор өргөдөл гаргагчид мэдэгдэл өгөхөөс татгалзах тодорхой үндэслэлийг гаргаж өгөх ёстой гэж Холбооны дээд шүүх шийдвэрлэсэн (Бонифас Окези Холбооны Ерөнхий прокурор, Эдийн засгийн эсрэг болон Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх хороо, Нигерийн Холбооны дээд шүүх, FHC/L/CS/514/2012 (2013 оны 2-р сарын 22).</p> <p>АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 31(5)</p>	<p>.хүсэлтийг буцаасан үндэслэл, хэлбэрийг албан ёсны бүртгэлд тэмдэглэх, мэдээлэл хүсэлтэд хариу өгөхдөө “үндэслэлийг тодорхой заах” үүрэгтэй (15.3). Мөн хуулийн 17.1.7-д заасны дагуу .хүсэлтэд дурдсан мэдээлэл нь хаалттай, эсхүл хүсэлт гаргагчид хамаарахгүй хязгаарлалттай мэдээлэл бөгөөд мэдээллийн эзний зөвшөөрөлгүй бол, эсхүл хүсэлт нь хуульд заасан шаардлагыг хангаагүй бол энэ талаар үндэслэл бүхий хариу өгөх ёстой. Татгалзсан хариуг заавал бичгээр өгөх зохицуулалт байхгүй бөгөөд хуулийн 15.5-д “Мэдээллийг амаар, бичгээр, цахим болон хуульд харшлахгүй бусад хэлбэрээр өгч болох бөгөөд хүн, хуулийн этгээдийг хүсвэл мэдээлэлтэй биечлэн танилцуулж болно” гэсэн байна.</p>
B11	Мэдээллийг нууцлах хугацааг олон нийтийн эрх ашгаас хамгаалахад зайлшгүй шаардлагатайгаас илүүгүй байхаар хуульчилсан уу ?	Тийм	<p>Мэдээллийг задруулснаас учрах хор хөнөөл нь уг мэдээллийг нийтийн тусын тулд ил болгосноос илүү хохиролтой байх тухайн хугацаанд л нууцална.</p> <p>АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 33(1)</p>	<p>Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу задруулбал учрах хохирлын хэмжээнээс хамаарч нууцал хамаарах мэдээллийг “онц чухал нууц”, “маш нууц”, “нууц” хэмээн гурван зэрэглэлд ангилах бөгөөд “онц чухал нууц” мэдээллийг 30 жил, “маш нууц”-ыг 20 жил, “нууц” мэдээллийг 10 жил нууцлахаар зохицуулжээ. Төрийн нууцын зэрэглэлийг ийнхүү ялгавартай тогтоосноор задруулснаас учирч болох гэм хорьц үнэлсний үндсэн дээр мэдээллийг нууцлах хугацаа, нэвтрэх эрх мэдлийг ялгавартайгаар, уян хатан байдлаар тогтоох зохицуулалтыг бий болгов.</p>
B12	Мэдээллийг нууцалж болох дээд хугацааг хуулиар хязгаарласан уу ?	Үгүй	<p>Нууцын тухай хуульд нууцлах дээд хугацааг тодорхой зааж өгсөн</p>	<p>Төрийн болон албаны нууцын тухай хуулиар “онц чухал нууц”-ыг 30 жил нууцална гэсэн хэдий ч, хуулийн 17.5”д</p>

			<p>байна. Тэрхүү хугацаа нь зайлшгүй шаардлагатайгаас ихгүй байх бөгөөд, мэдээллийг хэзээ ч тодорхойгүй хугацаагаар нууцлах ёсгүй.</p> <p>Жишээлбэл, Өмнөд Африкийн Мэдээллийн ил тод байдлыг дэмжих тухай хуульд мэдээлэл авах хүсэлт гаргах үед тухай мэдээлэл анх үүссэнээсээ хойш 20 жил болсон байх тохиолдолд үг мэдээллийг шууд ил болгохыг шаарддаг. Уганда улсын Мэдээллийн ил тод байдлын тухай хуульд мэдээллийг нууцлах ерөнхий хязгаарлалтыг 20 жилээр тогтоосон бол төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд саад учруулж болзошгүй мэдээллийг хамгаалах хугацааг 10 жилээр тогтоосон байдаг.</p> <p>АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 33(3).</p>	<p>“Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэлд хугацаа тогтоох боломжгүй бөгөөд тодорхой үйлдэл хийснээр, эсхүл үйл явдал болсноор ил болох бол тухайн нөхцөлийн дагуу нууцлах хугацааг тооцно.”</p> <p>17.6. Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхлын үүднээс цаашид үргэлжлүүлэн нууцлах шаардлагатай тохиолдолд тухайн нууцыг хариуцсан байгууллага, албан тушаалтан нь тагнуулын байгууллагын саналыг үндэслэн энэ зүйлийн 17.1-д заасан хугацаагаар нууцална.</p> <p>17.7. Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийн нууцлах хугацаа дууссан боловч тухайн мэдээллийг ил болгох эсэхийг шийдвэрлэх хүртэл мэдээллийг нууцална.” гэснээс үзвэл төрийн нууцад хамаатуулсан мэдээллийг хугацааны хязгааргүйгээр нууцлах боломжтой байна.</p>
B13	Мэдээлэл авах хүсэлтэд татгалзсан хариу өгсөн тохиолдолд өргөдөл гаргагч шийдвэрийн эсрэг давж заалдах буюу гомдол гаргах эрхтэй юу ?	Тийм	Мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдолд өргөдөл гаргагчийн асуудлыг ямар ч үнэ төлбөргүйгээр дотоод гомдол шийдвэрлэх журмаар түргэн шуурхай шийдвэрлэнэ. Дотоодын	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 15.3-т “Энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй, эсхүл урд өмнө нь хариу өгсөн асуудлаар дахин хандсан, эсхүл хүсэлтэд дурдсан мэдээлэл байхгүй бөгөөд хүсэлтийг холбогдох байгууллагад шилжүүлэх боломжгүй бол уг хүсэлтийг буцааж болох ба

			<p>гомдол шийдвэрлэх үйл ажиллагааны үр дүнгийн эсрэг тухайн газрын удирдлага, цаашлаад шүүхэд дахин гомдол гаргах боломжтой байна.</p> <p>АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 32</p>	<p>үндэслэлийг тодорхой заана.” гэж заасан. Хуулийн 14.1.6-д “мэдээлэл авах эрхийг нь зөрчсөн гэж үзвэл мэдээлэл хариуцагчийн дээд шатны байгууллага, албан тушаалтанд, дээд шатны байгууллага, албан тушаалтан байхгүй бол шүүхэд гомдол гаргах” эрийг баталгаажуулсан байна.</p> <p>Түүнчлэн захиргааны ерөнхий хуульд заасан журмаар мэдээлэл авах хүсэлтийг буцаасан шийдвэр, хариуг давж заалдах, гомдол гаргах, шүүхэд хандах эрх нь нээлттэй, уг эрхээ эдлэх бүрэн боломжтой юм.</p>
B14	<p>Мэдээллийг дотоодын хууль тогтоомжид заасан журмын дагуу шударгаар ил болгосон албан тушаалтныг хариуцлагаас хамгаалах тухай үндэсний хууль тогтоомжид заасан байдаг уу ?, Холбогдох хууль журам гэдэгт мэдээлэл авах эрхийн тухай хууль, эсхүл шүгэл үлээгчийн тухай хууль болон бусад зохицуулалт багтана.</p>	<p>Үгүй</p>	<p>Эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд ноцтой аюул занал учруулсан, хууль бус үйлдлийн талаарх мэдээллийг үнэн бодитой хэмээн итгэж, олон нийтийн эрх ашигт үйлчлэх зорилгоор нийтэд дэлгэснийх нь төлөө хэн ч иргэний, эрүүгийн, захиргааны, хөдөлмөрийн болон бусад төрлийн шийтгэл хүлээх ёсгүй.</p> <p>Төрөөс нууцыг олон нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн хамгаалалттайгаар ил болгох горимыг бий болгох, үүнд хяналт тавих бие даасан байгууллагыг бий болгох нь зүйтэй.</p> <p>АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 35. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн үзэл бодлоо</p>	<p>Мэдээллийг дотоодын хууль тогтоомжид заасан журмын дагуу шударгаар ил болгосон албан тушаалтныг хариуцлагаас хамгаалах тухай үндэсний хууль тогтоомжид тусгайлан заасан зохицуулалт байхгүй.</p>

			илэрхийлэх, мэдээлэл авах эрхийн талаарх <a href="#">баримтын цуглуулгыг үзнэ үү</a> .	
B15	Мэдээлэл олж авах эрхийн хэрэгжилт, мэдээлэл олж авахтай холбоотой маргааныг шийдвэрлэх, хянах, сурталчлах, хамгаалах бие даасан, хараат бус хяналтын механизмыг хуулиар бий болгосон уу ?	Тийм	Мэдээлэл олж авах эрхийн хэрэгжилтийг хянах, дэмжих, хамгаалах, мэдээлэл олж авахтай холбоотой маргааныг шийдвэрлэх бие даасан, хараат бус хяналтын механизмыг хуулиар тогтооно.  АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 34(1).	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд мэдээлэл олж авах эрх, хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ, зөвлөмж гаргах, гомдол гаргах, сурталчлах зэрэг чиг үүрэг бүхий механизмыг заасан байдаг. Үүнд:</p> <p>Уг хуулийн 14.2-д “Хүсэлт гаргагч мэдээлэл авах эрхээ хөндөгдсөн гэж үзвэл Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол гаргаж болно.” гэж заасан.</p> <p>Мөн уг хуулийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгуулахаар зохицуулсан нь хуулийн хэрэгжилтийг цаашид хангах, хууль сурталчлах, үнэлгээ хийхэд ач холбогдолтой механизм болсон байна.</p> <p>Уг хуулийн 8.17-д “Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий, Авлигатай тэмцэх газар, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана.”, 8.18-д “Энэ хуулийн 8.17-д заасан зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн болон цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж</p>

				заасан байдаг.
--	--	--	--	----------------

## С.ҮГ ХЭЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХЯЗГААР

№	Асуулт	Хариулт	Олон улсын болон бүс нутгийн хэм хэмжээний шилдэг туршлага, зөвлөгөө	Монгол Улсын нөхцөл байдал
C1	<p>Ялгаварлан гадуурхах, дайсагнах, хүчирхийлэл, үзэн ядалтыг өдөөн турхирах, үндэстэн, арьс өнгө, шашин шүтлэг, үзэн ядалтын бусад хэлбэрийг сурталчлахыг хуулиар хориглодог уу ?</p> <p>Өдөөн турхирах гэдэг нь ялгаварлан гадуурхах, дайсагнах, хүчирхийллийг өдөөхөд чиглэсэн тодорхой бөгөөд санаатай үйлдлийг хэлнэ. Ялгаварлан гадуурхах гэдэг нь арьсны өнгө, хүйс, шашин шүтлэг гэх мэт шинж чанарын эсрэг сөрөг үйлдэл хийхийг хэлнэ.</p> <p>Дайсагнал гэдэг нь зорилтот бүлэгт чиглэсэн доромжлол, дайсагнал, зэвүүцлийг</p>	Тийм	<p>Ялгаварлан гадуурхах, дайсагналд турхирах, хүчирхийллийг өөгшүүлэх, үндэстэн, арьс өнгө, шашны үзэн ядалтыг сурталчлахыг хуулиар хориглоно.</p> <p>АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 23 (2)-р зүйл: U.N.DOC.A/HRC/67/357; and U.N.Doc.A/HRC/74/486</p>	<p>Монгол Улсын Эрүүгийн хуулиар заналхийлэх, хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарлах, хувь хүний нууцад халдах, экстремист үйл ажиллагаа, үндэсний эв нэгдлийг бусниулах буюу хүмүүсийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашны номлол, үзэл бодлоор дайсагнуулах, эвдрэлцүүлэх, салан тусгаарлахыг ухуулах, уриалах, ялгаварлан гадуурхах, хүчирхийлэх, эрхийг нь хязгаарлах, давуу байдал тогтоох</p>

	<p>илэрхийлсэн хүчтэй, үндэслэлгүй сэтгэл хөдлөлийг хэлнэ.</p> <p>Хүчирхийлэл гэдэг нь бие махбодын болон сэтгэл санааны хохирол, шаналалд хүргэж болзошгүй аливаа үйлдлийг хэлнэ.</p>			<p>Үйлдлийг зохион байгуулахыг хориглосон байна.</p> <p>Харин ялгаварлан гадуурхах, дайсагнах, хүчирхийллийг өдөөхөд чиглэсэн санаатай, тодорхой өдөөн түрхирах үйлдэл болон шашны үзэн ядалтыг сурталчлах үйлдлийг Эрүүгийн хуулиар тусгайлан зохицуулаагүй байна.</p> <p>Түүнчлэн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31.1.1-д иргэд .бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй байх, өөрийн үзэл бодлыг илэрхийлэхдээ бусдын нэр төр, алдар хүндэд хүндэтгэлтэй хандах, гэмт хэрэг, зөрчилд бусдыг өдөөн хатгахгүй, олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журмыг гажуудуулах үйлдэл гаргахгүй байх үүрэгтэйг заасан. Мөн уг хуулийн 32.6-д хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүчирхийлэл, аллага хядлага, садар самуун, гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан, гэмт хэрэг үйлдэх аргыг нарийвчлан харуулсан, гэмт хэрэг, зөрчил үйлдэх, түүний ул мөрийг нуун далдлах арга, хэрэгслийг нарийвчлан дүрсэлсэн, гэмт хэрэг, зөрчлийг ашиг, орлогоо нэмэгдүүлэх хэрэгсэл болгон харуулсан, гэмт хэрэг, зөрчил үйлдэх сэдэл төрүүлж болох агуулгатай аливаа</p>
--	--	--	--	---

				мэдээллийг нийтлэх, нэвтрүүлэхийг хориглох тухай заасан байна.
C2	<p>Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх хуулийн хязгаарлалтыг зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох эцсийн арга нь эрүүгийн хариуцлага бөгөөд зөвхөн хамгийн хүнд тохиолдолд хэрэглэдэг үү?</p>	Тийм	<p>Ялгаварлан гадуурхалт, дайсагналд түрхирсан, хүчирхийллийг өөгшүүлсэн, үндэстэн, арьс өнгө, шашны үзэн ядалтыг сурталчилсны төлөө хүлээлгэх хариуцлагын хамгийн сүүлчийн арга хэлбэр нь эрүүгийн хариуцлага байж болох бөгөөд ингэхдээ дараах зүйлсийг заавал харгалзах ёстой:</p> <ul style="list-style-type: none"> <li>- зонхилж буй нийгэм, улс төрийн нөхцөл байдал,</li> <li>- үг хэлсэн болон сонссон хүмүүсийн төлөв, статус</li> <li>- өдөөн хатгах тодорхой зорилго байсан эсэх,</li> <li>- ярианы агуулга, хэлбэр,</li> <li>- үг ярианы цар хүрээ, түүний олон нийтийн шинж чанар, мэдээлэл хүлээн авагчдын тоо, түгээх арга хэрэгсэл,</li> <li>- хохирлын бодит магадлал ба цаг хугацааны ойрын байдал</li> </ul> <p>АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 22 (3)</p>	<p>Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх хуулийн хязгаарлалтыг зөрчсөн буюу Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд Эрүүгийн хариуцлага хүлээдэг. Эрүүгийн хариуцлагыг хүлээлгэхдээ Эрүүгийн хуульд заасан хөнгөрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзнэ. Мөн хэргийн нөхцөл байдал, эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ зонхилж буй нийгэм, улс төрийн нөхцөл байдал, үг хэлсэн болон сонссон хүмүүсийн төлөв, статус, өдөөн хатгах тодорхой зорилго байсан эсэх, ярианы агуулга, хэлбэр, үг ярианы цар хүрээ, түүний олон нийтийн шинж чанар, мэдээлэл хүлээн авагчдын тоо, түгээх арга хэрэгсэл, хохирлын бодит магадлал ба цаг хугацааны ойрын байдал зэргийг мэтгэлцээний явцад гаргаж тавих, шүүх харгалзан үзэх боломжтой.</p>

## D. ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ ГҮТГЭЛЭГ

№	Асуулт	Хариулт	Олон улсын болон бүс нутгийн стандартаар тогтоосон сайн туршлага/удирдамж	Монгол Улсын нөхцөл байдал
D1	Гүтгэлгийг Эрүүгийн хуулиар шийтгэдэг үү?	Тийм →	Улс орнууд үймээн самуун дэгдээх, доромжлох, гүтгэх, худал мэдээлэл нийтэлсний төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг хуулиа хүчингүй болговол зохино. Гүтгэлэгтэй холбоотой асуудлыг эрүүгийн хуулиар бус, иргэний хариуцлага хүлээлгэх өөрчлөлт оруулах, уучлалт гүйх, засаж залруулах, тодруулах гэх мэт нэр хүндэд хохирол учруулсан тохиолдолд мөнгөн бус хариуцлагын арга хэмжээг хуулиар дамжих арга хэмжээг зөвлөж байна. АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 22(2) and (3). See also <a href="#">U.NDOC.A/HRC/38/35</a>	Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13.14 дүгээр зүйлээр хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол, мөн уг хуулийн 14.8 дугаар зүйлээр сонгуульд оролцогч улс төрийн нам, намүүдын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан бол эрүүгийн гэмт хэрэгт тооцож холбогдох шийтгэлийг оноох тухай зохицуулсан.
D2	Аливаа мэдээлэл дараах бүх шалгуурыг хангасан тохиолдолд л гүтгэлэг хэмээн үзэх тухай хуульд заасан уу: <ul style="list-style-type: none"> <li>• яриа, бичгээр, зургаар, дохио зангаагаар олон нийтийн хүртээл болсон;</li> <li>• худал (өөрөөр хэлбэл, агуулга нь бүрэн худал);</li> <li>• хор хохирол учруулахуйц</li> </ul>	Үгүй →	Гүтгэлгийн олон улсын эрх зүйн тодорхойлолтыг НҮБ-ын дараах баримт бичигт тусгасан байдаг. А/HRC/4/27 27-р хэсэг	Дээр дурдсан Эрүүгийн тухай хуулийн заалтаас гадна Зөрчлийн тухай хуулийн 5.20, Төрийн албаны тухай хуулийн 61-р зүйл, Цагдаагийн албаны тухай үүлийн 22.4, 48.2 дугаар зүйл, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай үүлийн 6.3, Монгол Улсын Их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.10, зэрэг дотоодын хэд хэдэн хууль тогтоомжид гүтгэх,



	<ul style="list-style-type: none"> <li>• уг мэдээллийг түгээсэн этгээд хамгаалагдсан ангилалд хамаарахгүй. Жишээ нь, мэдээлэл түгээсэн хэн нэгэн ажил мэргэжлийн хувьд "давуу эрхтэй" бөгөөд хэлсэн зүйлийнх нь төлөө гүтгэсэн хэргээр шүүхэд нэхэмжлэл гаргах боломжгүй.</li> <li>• мэдээллийг зориудаар, хор хөнөөл учруулах зорилгоор түгээсэн</li> </ul>			<p>доромжлох, гутаах гэсэн нэр томьёо ижил утгаар ашигласан заалтууд бий. Гэвч мэдээллийг ямар тохиолдолд гүтгэлэгт тооцох тухай шалгуур, тодорхойлолт байхгүй, ийм төрлийн мэдээллийг зориудаар түгээсэн эсэхийг харгалздаггүй, мөн “олон нийтийн хүртээл болгосон” байх шалгуурыг дээр дурдсан хуулиудад тусгаагүй байна.</p>
D3	<p>Гүтгэлгийн тухай хуулийн тодорхойлолтод улс, үндэстэн, төрийн бэлгэдэл зэрэг утга санааг гажуудуулсан худал мэдээллийг бус гагцхүү хувь хүний тухай мэдээллийг хамаатуулан томьёолсон үү?</p>	Үгүй	<p>Гүтгэлгийн тухай хуулийн тодорхойлолтод хувь хүний тухай худал мэдээллээр хязгаарлагдах ёстой U.N.DOC.A /HRC/4/27 54-р хэсэг</p>	<p>Эрүүгийн хуулийн (шинэчилсэн найруулга) 13.14 дүгээрт гүтгэх, доромжлох тухай ойлголтыг нэгтгэж, “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараах”-ыг хориглох тухай заалт оруулсан нь гүтгэлгийн тухай томьёоллыг илүү өргөн хүрээний ойлголт байхаар тусгасан. Ингэхдээ “гүтгэлэг” гэдэгт хувь хүний тухай худал мэдээллийг хамаатуулахаас гадна “хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдах” гэх ойлголтыг давхар ашиглаж байгаа нь олон улсын хэм хэмжээнд нийцэхгүй байна.</p>
D4	<p>Төр, засаг улс төрийн албан тушаалтнууд шүүмжлэлд илүү хүлээцтэй хандахыг шаарддаг үү?</p>	Үгүй	<p>Олон нийтийн өмнө үүрэг, хариуцлага хүлээсэн хүмүүс энгийн иргэдтэй харьцуулбал илүү өргөн хүрээний шүүмжлэл, олон нийтийн хяналтыг “хүлээн зөвшөөрөхөд бэлэн байх ёстой”</p>	<p>Ийм хуулийн зохицуулалт байхгүй .</p>

## Е. ОНЛАЙН КОНТЕНТЫН ЗОХИЦУУЛАЛТ

E1	<p>Дамжуулагчид өөрийн сувгаар гуравдагч этгээдийн контент нийтэлсний төлөө хариуцлага хүлээхгүй байх хуулийн хамгаалалт бий юу?</p> <p>Жич: “Дамжуулагч” гэдэгт Интернэт үйлчилгээний компани, хайлтын систем, социал медиа компани зэрэг Интернэтийн хэрэглээг дэмждэг компаниудыг ойлгоно.</p>	Үгүй	<p>Дамжуулагчид гуравдагч этгээдийн контентыг өөрийн сувгаар нийтэлсний төлөө хариуцлага хүлээх ёсгүй</p> <p>НҮБ-ын DOC.A/HRC/38/35, 14-16-р хэсэг</p>	<p><b>Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3.1-д</b> Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ” хэмээн заасан. Гэвч “хэвлэл мэдээллийн хэрэгсэл” гэдэгт ямар хэрэгслийг багтаах тухай хууль эрх зүйн тодорхойлолт байхгүй. Зар сурталчилгааны тухай хуулийн 3.1.5-д “мэдээлэх хэрэгсэл” гэж телевиз, радио, холбооны шугам сүлжээ, компьютерын сүлжээ, тусгай программ, хэвлэл болон бусад арга хэрэгслийг хэлнэ хэмээн заасан.</p> <p><b>Харилцаа холбооны тухай хуулийн 16.1-д</b> Харилцаа холбооны сүлжээ нь цахилгаан холбоо, шуудан, радио, телевизийн болон мэдээллийн /интернет, компьютер зэрэг бусад/ сүлжээнээс бүрдэнэ гэж тодорхойлсон. Өөрөөр хэлбэл мэдээллийн олон янзын эх үүсвэр болон түгээж буй сувгуудыг ялгаж салгасан нэр томьёо тодорхойлолт байхгүй. “Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журам”-ын 1.3-т “Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, интернэтийн үйлчилгээ эрхлэгч болон цахим орчны үйлчилгээ эрхлэгч (цахим</p>
----	---	------	--	--

				<p>хуудас, цахим орчин дахь олон нийтийн сүлжээ, аппликэйшн, гэх мэт)-ийг цар тахлын талаар худал мэдээлэл тараахаас сэргийлэх журамд захирагдаж, хариуцлага хүлээх субъектууд мөн хэмээн тодорхойлсон. Улмаар цар тахлын талаарх худал мэдээлэлтэй тэмцэх журмын дагуу Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран ажиллах үүрэгтэй, журмыг биелүүлэхгүй бол Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хуулийн дагуу хариуцлага хүлээх тухай зохицуулжээ.</p> <p>ХХЗХ-ны “Контентын үйлчилгээ эрхлэх зохицуулалтын журам”-ын 1.3-д Интернэтийн үйлчилгээ эрхлэгч, үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, суурин холбооны үйлчилгээ эрхлэгч болон контентын үйлчилгээ эрхлэгчид захирагдах ёстойг тодорхойлж, контентын зөрчилтэй холбоотойгоор зөрчлийг арилгуулах талаар холбогдох төрийн байгууллагаас хугацаатай үүрэг даалгавар, шаардлага, мэдэгдэл хүргүүлэх; .контентын үйлчилгээний Монгол Улсаас хандах хандалтыг мэдээллийн сүлжээнд хязгаарлахыг заасан байна.</p>
E2	Хэрэглэгчийн үүсгэсэн контентыг дамжуулагчид хянах, үстгахыг хуулиар шаарддаг уу?	Тийм →	Төрөөс дамжуулагч компаниудад контентын хязгаарлалт хийх шаардлага тавих ёсгүй. Тийм шаардлага тавих тохиолдолд тэдгээр	ХХЗХ-ны “Контентын үйлчилгээ эрхлэх зохицуулалтын журам”-ын 4.1.4-ийн дагуу контентын үйлчилгээ эрхлэгчид “Монгол Улсын хууль зөрчсөн нь холбогдох эрх бүхий

			<p>нь дараах шалгуурыг хангасан байна.</p> <p>А. Тодорхой, давхар утга санаа илэрхийлээгүй,</p> <p>Б. Хараат бус шүүхийн байгууллагаас шийдвэрлэсэн байх,</p> <p>В. Хувь хүн, хүүхэд шууд аюул заналхийлэл, үхэх эрсдэл болон бусад ноцтой аюул учруулж буй контентыг устгах тухай хууль сахиулагч байгууллагаас санал болгосон байх, тухайн саналыг хэрэгжүүлэх эсэхийг шүүхээр тогтоосон байх,</p> <p>Г. Зохих журмын дагуу хамгаалагдсан байх,</p> <p>Д. Үндэслэлтэй, олон улсын хүний эрхийн хууль, стандартад нийцсэн байх,</p> <p>Е. Давж заалдах эрхийг баталгаажуулсан, ил тод үйл явцаар хэрэгжих</p> <p>АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 39 (4)</p> <p>Дамжуулагч этгээдийн хариуцлагын тухай Манилагийн зарчим, Зарчим 3</p>	<p>байгууллагын дүгнэлт, шийдвэрээр тогтоогдсон контент, контентын үйлчилгээг устгах, хязгаарлах техникийн боломжийг хангасан байх” үүрэгтэй. Уг журмын 5.1-ийн дагуу “Зохицуулах хороо эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хууль тогтоомж зөрчсөн тухай дүгнэлт, шийдвэрт үндэслэн холбогдох технологийн арга хэмжээ авах мэдэгдлийг үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлэх бөгөөд уг мэдэгдлийг нэн даруй хэрэгжүүлнэ” гэж заасан. Тийнхүү авах арга хэмжээнд “5.3.1.мэдэгдэлд дурдсан контентыг эрх бүхий байгууллагаар шалгагдаж дуусах хугацаанд түр хязгаарлах; 5.3.2.мэдэгдэлд дурдсан хууль зөрчсөн контентыг устгах” зэрэг орж байна.</p> <p>Уг журамд захирагдаж, холбогдох үүрэг даалгаврыг биелүүлэх ёстой этгээдэд “үйлчилгээ эрхлэгчид” буюу интернэтийн үйлчилгээ эрхлэгч, үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, суурин ХХЗХ-ны “Контентын үйлчилгээ эрхлэх зохицуулалтын журмын 5.1-д контентын зөрчилтэй холбоотой аливаа арга хэмжээ авахдаа Зохицуулах хороо эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хууль тогтоомж зөрчсөн тухай дүгнэлт, шийдвэрт үндэслэх туай заасан.</p>
ЕЗ	Дамжуулагчаас контент устгах, хязгаарлахыг шаардахын тулд шүүхийн шийдвэрт үндэслэх	Тийм	Албан тушаалтнууд дамжуулагч компаниас контент устгахыг	Зохицуулах хороо эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хууль тогтоомж зөрчсөн тухай дүгнэлт,

	ёстойг хуулиар баталгаажуулсан уу?		шаардахын тулд шүүхийн захирамж авсан байх ёстой. АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 39 (5) Дамжуулагч этгээдийн хариуцлагын тухай Манилагийн зарчим, Зарчим 2 НҮБ-ын DOC/A/HRC/38/35, 66-р хэсэг	шийдвэрт үндэслэн контент устгах, хязгаарлахын шаардана.
E4	Дамжуулагч компани хууль бус контентыг устгаагүй бол хуулиар хатуу шийтгэл оноодог уу? (жишээлбэл: өндөр дүнтэй мөнгөн торгууль, хорих ял гэх мэт)	Тийм	Төрөөс дамжуулагч компаниудад хэт өндөр торгууль, хорих ял гэх мэт хэрээс хэтэрсэн хатуу шийтгэл оноох нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд ихээхэн сөрөг нөлөө үзүүлэхийг харгалзаж, ийм шийтгэл оноохоос татгалзах ёстой. НҮБ-ын DOC/A/HRC/38/35, 66-р хэсэг	<p><b>Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга /</b>  <b>16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах</b></p> <p>1. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>2. Энэ гэмт хэргийг:</p> <p>2.1.кибер орчныг ашиглаж;</p> <p><u>/Энэ хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</u></p> <p>2.2. Бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр</p>

				торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Хэвлэн нийтлэгч, дамжуулагчдыг эрх зүйн хувьд тодорхой томъёолоогүй учир энэхүү ял шийтгэлийг контент үйлдвэрлэгч болон дамжуулагчийн аль аль нь хүлээх боломжтой байна.
E5	Тухайн улсын газар нутгаас гадуурх дамжуулагчийн байршуулсан холбоос, вэбсайт эсвэл контентыг устгахыг хуулиар шаарддаг уу?	Үгүй	Гадаадын дамжуулагчдын байршуулсан контентыг устгахыг эрэлхийлж буй улс орнууд хууль эрх зүйн болон шүүхийн журмын дагуу холбогдох газарт хүсэлт гаргах ёстойг хуулиар шаардвал зохино. НҮБ-ын DOC/A/HRC/38/35, 18-р хэсэг	Хуулиар тусгайлан заавал үүрэг болгосон зохицуулалт байхгүй, харин ийм төрлийн эсрэг маргааны оролцогчид прокурорт хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх эсэх нь нээлттэй боловч прокурор хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх эсэх нь үзэмжийн асуудал юм.

## Г. МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ БА ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

F1	Сонин, сэтгүүл, радио, телевиз, онлайн хэрэгсэл зэрэг төрөл бүрийн хараат бус мэдээллийн хэрэгсэл үүсгэн байгуулах эрхийг хуулиар баталгаажуулсан уу?	Үгүй →	Хэвлэмэл, өргөн нэвтрүүлгийн болон цахим мэдээллийн хэрэгслийг хараат бусаар үүсгэн байгуулах эрхийг төрөөс баталгаажуулах ёстой АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 12 (1)	ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ 8.1 дүгээр зүйлийн 9-д Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно: Харилцаа холбооны зохицуулах хорооноос: 9.2. Арилжааны радио, телевизийн үйлчилгээ эрхлэх, 9.3. Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх,
----	---	--------	---	---

				<p>9.4. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх, 9.5. Олон нийтийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх, 9.6. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх, 9.7. Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх, 9.8. Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах, 9.9. Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх, 9.14. Төлбөртэй радио, телевизийн үйлчилгээ эрхлэх</p> <p><b>9.7 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох</b></p> <p>1.Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p> <p><b>АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ 15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл</b></p> <p>15.1. Энэ зүйлд заасан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ.</p> <p>15.16. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр:</p> <p>15.16.1. Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах; 15.16.2. Харилцаа холбооны үйлчилгээний сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх. 15.16.3. Контентийн үйлчилгээ эрхлэх.</p>
--	--	--	--	---

				<p>15.16.5. Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ;</p> <p>15.16.6. Радио, телевизийн үйлчилгээ:</p> <p>15.16.6.а. Олон нийтийн радио, телевиз;</p> <p>15.16.6.б. Арилжааны радио, телевиз;</p> <p>15.16.6.в. Өргөн нэвтрүүлгийн радио, телевиз;</p> <p>15.16.6.г. Төлбөртэй радио, телевиз.</p> <p>15.16.7. Олон суваг дамжуулах үйлчилгээ.</p>
F2	<p>Хэвлэл мэдээллийн олон талт, олон ургалч байдлыг хуулиар хамгаалдаг уу?</p> <p>/жишээлбэл: цахим ба хэвлэл мэдээллийн хэрэгсэл, радио, телевизийн салбарт төрийн болон хувийн компани ноёрхол тогтоогоогүй/</p>	Үгүй →	<p>Хэвлэл, өргөн нэвтрүүлэг, онлайн мэдээллийн хэрэгслийн салбар дахь төрийн болон хувийн хэвшлийн монополизм нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцэхгүй</p> <p>АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 11 (1)</p>	<p>Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 2 дугаар зүйлд хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглох тухай заасан.</p> <p>Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар өргөн нэвтрүүлгийн салбарт хэт төвлөрлөөс хамгаалах тухай зохицуулалт орсон боловч хэвлэл мэдээллийн эзэмшлийн төвлөрлийг хэмжих, тодруулах ямар нэгэн зохицуулалт, хэмжүүр, шалгуур байхгүй.</p> <p>Цахим орчинд болон хэвлэмэл мэдээллийн салбарт ийм зохицуулалт байхгүй олон ургальч байдлыг хуулиар, хамгаалдаггүй</p>
F3	<p>Хэвлэл мэдээллийн агуулгатай холбоотой гомдлыг хянан шийдвэрлэх олон нийтийн санал гомдлын тогтолцоог хуулиар бий болгосон уу?</p>	Зарим талаар	<p>Хэвлэл, өргөн нэвтрүүлэг, онлайн мэдээллийн хэрэгсэл, интернэтийн орчин дахь дамжуулагчдын талаарх олон нийтийн санал, гомдол шийдвэрлэх тогтолцоог тогтоосон дүрэм, ёс зүйн дүрмийн дагуу үүсгэн</p>	<p>Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 12 дугаар зүйлд олон нийтийн радио, телевизийн агуулгын талаарх санал, гомдлыг шийдвэрлэх тухай заасан.</p>



			байгуулж, өргөн олонд нээлттэй, хүртээмжтэй байлгах ёстой	
F4	Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын аюулгүй байдлыг алдагдуулсан, эсхүл заналхийлэл учруулсан хууль сахиулах, тагнуул, цэргийн болон бусад ажиллагаа явуулсны төлөө төр хариуцлага хүлээх тухай хуулийн зохицуулалт бий юу?	Тийм	Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын аюулгүй байдлыг алдагдуулсан, эсхүл заналхийлэл учруулсан хууль сахиулах, тагнуул, цэргийн болон бусад ажиллагаа явуулсны төлөө төр хариуцлага хүлээх ёстой. АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 20 (5)	<b>Эрүүгийн хууль</b> <b>14.3 дугаар зүйлд</b> “өөрийн, эсхүл бусдын хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, тараалгахгүй байхын тулд хэвлэн нийтлэгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл төлбөр төлж зориуд нийтлүүлээгүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлэх”-ийг хориглосон.
F5	Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд мэдээллийн нууц эх сурвалж, ажил мэргэжлийн зорилгоор хадгалж буй бусад материалыг зөвхөн шүүхээр нээлттэй, бүрэн дүүрэн, шударгаар хэлэлцэж шийдвэрлэсний үндсэн дээр илчлэхийг хуулиар шаарддаг уу?	Зарим талаар	Шүүхийн нээлттэй, шударга хэлэлцүүлэгт үндэслэн шийдвэрлэснээс бусад тохиолдолд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудаас мэдээллийн нууц эх сурвалжийг илчлэх, ажил мэргэжлийн зорилгоор эзэмшиж буй бусад материалыг ил болгохыг шаардах ёсгүй. Шүүхээр зөвхөн дараах тохиолдолд мэдээллийн эх сурвалжийг ил болгох тухай захирамж гаргахыг зөвлөж байна. А. Онц хүнд гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах, эрүүгийн хэрэгт яллагдагчийг өмгөөлөхөд эх сурвалжийг тогтооход зайлшгүй шаардлагатай,	Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 34.2-т “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж шүүх үзэж ил болгосноос бусад тохиолдолд олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эрх сурвалжийг нууцлах эрхтэй хэмээн заасан. Бусад сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эх сурвалжаа нууцлах эрхийг хуулиар баталгаажуулаагүй.

			<p>Б. Ижил үр дүнд хүргэх мэдээлэл эсвэл ижил төстэй мэдээллийг өөр газраас олж авах боломжгүй,  В. Олон нийтийн эрх ашгийн үүднээс эх сурвалжийг ил болгох нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд учруулах хор хөнөөлөөс давуу байх  АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 25 (1)</p>	
F6	<p>Сэтгүүлчийн нууц эх сурвалжийн яриаг чагнах, харилцаа холбоог тагнахын тулд хараат бус шүүхийн захирамжид үндэслэх ёстойг хуулиар баталгаажуулсан уу?</p>	Тийм	<p>Төрөөс харилцаа холбооны тандалт хийх замаар мэдээллийн нууц эх сурвалжийн хамгаалалтыг тойруу замаар зөрчих ёсгүй. Ийм төрлийн үйл ажиллагаа зөвхөн шударга, хараат бус шүүхээр шийдвэрлэж, зохих хамгаалалтад хамруулсан тохиолдолд зөвшөөрч болно.  АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 25 (3)</p>	<p><b>ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН 22.1 дүгээр зүйлд . мөрдөн шалгах ажиллагааны явцад</b> мөрдөгч үзлэгийг нууцаар хийх, нэгжлэг хийх, эд зүйл, баримт бичиг хураан авах харилцаа холбооны сүлжээнд нэвтэрч, хяналт тогтоох, харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгыг холбогдох байгууллагаас гаргуулан авах, харилцаа холбооны сүлжээний хэрэглэгчийн мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах, харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарлах талаар холбогдох байгууллагад даалгах, мөрдөн шалгах нууц түршилт, нууц ажиглалт, таньж олуулах ажиллагааг нууцаар хийхийг прокурорын зөвшөөрлөөр явуулах тухай заасан.  Уг хуулийн <b>22.3 дугаар зүйлийн дагуу</b></p> <p>прокуророос мөрдөх үйл ажиллагааны зөвшөөрөл олгох тохиолдолд уг зөвшөөрөлд нууцаар мөрдөх ажиллагааны зорилго, хуагцаа, газар,</p>

				<p>объект, хамрагдах хүн, зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа зэргийг тодорхой тусгах үүрэгтэй.</p> <p><b>22.4 дүгээр зүйлд</b> хойшлуулшгүй тохиолдолд мөрдөн шалгах ажиллагааг прокурорын зөвшөөрөлгүй явуулж болох тухай заасан. Ийм тохиолдолд мөрдөх үйл ажиллагааны талаар прокурорт нэн даруй мэдэгдэх, мөрдөх ажиллагаа дууссаны дараа 24 цагийн дотор прокуророос тухайн ажиллагааг зөвшөөрөлгүй явуулах үндэслэл нотолгоо уг ажиллагааг хүчинтэйд тооцуулах хүсэлтийн хамт хүргүүлэх үүрэгтэй. Прокурор мөрдөгчөөс ирүүлсэн нотлох баримт, тайлбартай танилцсаны .мөрдөн шалгах ажиллагааг хүчинтэйд тооцох эсэх, мөн мөрдөн шалгах ажиллагаа, нотлох баримтыг хүчингүй болгох эсэхийг 24 цагийн дотор шийдвэрлэж, хэрэв хүчингүйд тооцсон бол мөрдөх үйл ажиллагааны явцад хураан авсан эд зүйл, баримт бичгийг эзэмшигчид нь эргүүлэн олгохыг даалгана.</p>
F7	Сэтгүүлчдэд сайн дураар мэдээлэл өгсөн эх сурвалжийг шүгэл үлээгчийн тухай хуулиар хамгаалдаг уу?	Үгүй →	Эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд ноцтой аюул занал учруулсан, хууль бус үйлдлийн талаарх мэдээллийг олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор, тухайн мэдээлэл ерөнхийдөө үнэн бодит гэдэгт итгэж нийтэд дэлгэсэн хэнд ч иргэний,	Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг 2021 оны 11 сард Монгол Улсын Засгийн газраас 5 бүлэг 22 зүйлтэйгээр боловсруулж УИХ-д өргөн барьж байсан ч хэлэлцэгдэж батлагдаагүй байна.

			<p>эрүүгийн, захиргааны, хөдөлмөрийн болон бусад төрлийн шийтгэл хүлээлгэж болохгүй.</p> <p>АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 35. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх НҮБ-ын тусгай илтгэгчийн үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхийн талаарх баримтын цуглуулгыг үзнэ үү.</p>	
--	--	--	---	--

## G. ИНТЕРНЭТТЭЙ БАЙХ ЭРХ

№	Асуулт	Хариулт	Олон улсын болон бүс нутгийн стандартаар тогтоосон туршлага/удирдамж сайн	Монгол Улсын нөхцөл байдал
G1	Төрөөс интернэттэй байх эрхийг баталгаажуулах зорилгоор бүх нийтийг хамарсан, тэгш байдлыг хангасан хууль тогтоомж, бодлого, бусад арга хэмжээ авсан уу?	Тийм	<p>Төрөөс авч хэрэгжүүлж болох бодлого, арга хэмжээний зарим жишээ:</p> <ul style="list-style-type: none"> <li>•үр дүнтэй хяналт тавих бие даасан, ил тод зохицуулалтын механизмыг хөгжүүлэх;</li> <li>•бүх нийтийг хамарсан мэдээлэл, харилцаа холбооны технологи, интернэтийн дэд бүтцийг сайжруулах;</li> <li>•хямд үнийг дэмжих, олон талт байдлыг дэмжих зорилгоор зах зээлийн өрсөлдөөнийг зохицуулах механизмыг бий болгох;</li> </ul>	<p>Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.6.4.4-т “Нийгэмд мэдээллийг хүртээмжтэй, түргэн, шуурхай хүргэх мэдээллийн хэрэгсэл, дэд бүтцийн хөгжлийг дэмжиж найдвартай ажиллагааг хангана” гэж заасан.</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилго 5-д цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжинэ гэж, зорилт 5.3-т “Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ” гэж заасан. Энэ зорилтыг хэрэгжүүлэх 23 үйл ажиллагааг Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар</p>

		<ul style="list-style-type: none"> <li>•эмзэг бүлэг, үйлчилгээ хүрээгүй, эсвэл дутмаг газарт нийтэд нээлттэй холболтыг нэмэгдүүлэх олон нийтийн сүлжээ зэрэг орон нутгийн хандалтын санаачилгыг дэмжих;</li> <li>•хүртээмжтэй, бие даасан хэрэглээг хөгжүүлэх зорилгоор дижитал бичиг үсгийн ур чадварыг дэмжих АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 37(3).</li> </ul>	<p>хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-нд заасан.</p> <p>Засгийн газрын 2005 оны 216 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Цахим монгол” үндэсний хөтөлбөр 2005-2012 онд хэрэгжсэн. Энэ хөтөлбөр хэрэгжсэнээр Монгол Улсын интернэтийн гадаад гарцын багтаамж 2005 онд 78Мбит/с, интернэт хэрэглэгч 22000, өргөн зурвасын шилэн кабелийн урт 3251 км, үүрэн холбооны хэрэглэгч 551000 байсан бол 2012 онд интернэтийн гадаад гарцын багтаамж 22Гбит/с, интернэт хэрэглэгч 654009, өргөн зурвасын шилэн кабелийн урт 18123.8 км, үүрэн холбооны хэрэглэгч 3409005 болж өсжээ.</p> <p>Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022.05.18-ны өдрийн А/24 дүгээр тушаалын хавсралтаар “Цахим үндэстэн” баримтлах чиглэл /2022-2027/-г баталсан. Энэ чиглэлд 6 зорилтыг тусгасан.</p> <p>Монгол Улсад интернэтийн гадаад гарцын урсгалын хэмжээ 780 Гбит/сек, интернэт хэрэглэгчид давхардсан тоогоор 5,450,610 хүрснээс 94,41% нь хөдөлгөөнт өргөн зурвасын үйлчилгээг хэрэглэж байна. Хөдөлгөөнт холбооны 4 дэх үеийн технологийг 2016 онд нэвтрүүлэн 2021 оны байдлаар 2 сая 900 мянга гаруй хэрэглэгчтэй болсон.</p> <p>Үндэсний статистикийн хороо, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2021 онд хамтран хэрэгжүүлсэн “Өрхийн болон хувь хүний мэдээлэл, технологийн хэрэглээ” судалгаанд дурдсанаар, тус судалгаанд оролцогчдын 43.8% нь интернэтээс мэдээлэл олж авах ур чадвартай, 38.8% нь интернэтийг</p>
--	--	---	---

				<p>харилцаа холбоондоо ашиглах үр чадвартай, 27% нь асуудал шийдвэрлэх буюу интернэт дэх үйлчилгээ, програмыг өдөр тутамдаа ашиглах, 9.8% нь програм хангамжийн, 6.4% нь аюулгүй байдлын үр чадвартай байна. Үүнтэй холбоотойгоор Боловсрол, шинжлэх ухааны сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Соёлын сайд нарын 2022.07.25-ны өдрийн А/260/391/146/260 дугаар тушаалын хавсралтаар “Бүх нийтийн цахим үр чадвар, чадамжийг дээшлүүлэх төлөвлөгөө”-г баталсан. Тус төлөвлөгөөг 2022-2026 онд хэрэгжүүлнэ.</p> <p>Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020.12.04-ний өдрийн 02/10 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.3.2-т “Улаанбаатар хотын алслагдсан гэр хороолол болон хүн амаар ихээр цуглардаг тодорхой бүсүүдийг үе шаттайгаар утасгүй интернэтжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ” гэж заасан.</p>
G2	Төрөөс интернэт болон бусад дижитал технологийн хүртээмжийг тасалдуулахыг хуулиар хориглосон уу?	Үгүй	Иргэний хэсэг бүлэг, олон нийтийн Интернэт болон дижитал технологи ашиглах эрхийг хязгаарлах, тасалдуулах аливаа үйл ажиллагааг төрөөс хэрэгжүүлэх ёсгүй. АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 38(2).	Харилцаа холбооны зохицуулах хорооны 2011 оны 08 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”, Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам”, “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн 9.13-т заасны дагуу Цагдаагийн ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2020

				<p>оны А/200, А/169 дүгээр хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журам”-ын зохицуулалт нь зөвхөн эрх бүхий байгууллагын дүгнэлт, саналд тулгуурлан цахим орчин дахь агуулгыг хязгаарлах, үстгахад чиглэсэн байх бөгөөд тэрхүү дүгнэлт, саналд хөндлөнгийн этгээд буюу шинжээчийн дүгнэлт гаргуулах нөхцөл тусгагдаагүй нь цахим орчин дахь мэдээллийн төөрөгдөл, үзэн ядалтыг дэвэргэсэн агуулгаас хамгаалах нэрийн дор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийг зохисгүйгээр хязгаарлах эрсдэлийг бий болгож байна. Харилцаа холбооны зохицуулах хорооноос дээрх журмуудын дагуу шийдвэрлэж буй гомдлын агуулга, шийдвэрийн талаар тухай бүр цахим хуудсаараа дамжуулан ил тод мэдээлдэггүй, зөвхөн тоон мэдээг сүүлд товч дурдаж байгаа нь дээрх эрсдэл бодитой болохыг харуулж байна.</p>
G3	<p>Мэдээлэл, харилцаа холбооны технологийн (МХХТ) үйлчилгээний эцсийн хэрэглэгчдэд татвар ноогдуулдаг уу (тухайлбал социал медиа татвар)?</p>	Үгүй	<p>Төрөөс МХХТ-ийн үйлчилгээний эцсийн хэрэглэгчдэд ногдуулах татвар, хураамж нь интернэтийн тэгш, боломжийн, утга учиртай хүртээмжийг алдагдуулахгүй байх ёстой. АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 38(3).</p>	<p>Татварын ерөнхий хуулийн 7.2-т зааснаар Монгол Улсад нийт 30 төрлийн татвар бий. Эдгээр татвар нь мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний эцсийн хэрэглэгчид хамаарахгүй.</p>

## Н. ХУВИЙН ХАЛДАШГҮЙ БАЙХ ЭРХ: МӨРДӨН МӨШГӨХӨӨС АНГИД БАЙХ

<p>Н1</p>	<p>Хүний хувийн нууц, гэр бүл, орон байр, захидал харилцааны нууцад дур мэдэн буюу хууль бусаар хөндлөнгөөс оролцох, мөн нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахаас хамгаалагдах эрхийг хуулиар баталгаажуулсан уу?</p> <p>"Хөндлөнгөөс оролцох" гэж хувь хүнийг хөндлөнгөөс хянахыг хэлэх бөгөөд тухайн хүн мэдээллээ илгээх, хүлээн авах үйл явц үргэлжлэх үеийн хянах үйл ажиллагааг ч хамаатуулна. Хяналтын технологид битүү хэлхээний буюу кабелийн телевиз, дрон, тагнуулын программ зэрэг хөгжиж буй технологи орно.</p> <p>"Хууль бус" гэж хуульд заагаагүй нөхцөл байдалд хөндлөнгөөс оролцохыг хэлнэ.</p>	<p>Тийм</p>	<p>Хувийн нууцаа хамгаалуулах эрх нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай. Хүний хувийн нууц, гэр бүл, орон гэр захидал харилцааны нууцад дур зоргоороо, хууль бусаар халдаж, нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдахыг хуулиар хориглох ёстой .</p> <p>НҮБ DOC. A/HRC/23/40, 24-р хэсэг. Америкийн хүний эрхийн конвенцийн удиртгал болон зарчим 40;</p> <p>ИБУТЭТОУП-ын 17-р зүйл.</p>	<p>2017.05.18-ны өдөр батлагдаж, 2017.07.01-нээс эхлэн хүчин төгөлдөр болж үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хүний халдашгүй байх эрхэд халдахад чиглэсэн ажиллагааг зохицуулсан. Тодруулбал, 23.2 дугаар зүйлд хүний биед үзлэг хийх, 24.1 дүгээр зүйлд нэгжлэг хийх, 24.2 дугаар зүйлд хүний биед нэгжлэг хийх, 24.3 дугаар зүйлд орон байр, бусад газарт нэгжлэг хийх, 24.4 дүгээр зүйлд эд мөрийн баримт хураан авах, 24.5 дугаар зүйлд мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах, 26.1 дүгээр зүйлд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах, 26.2 дугаар зүйлд харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох, 26.3 дугаар зүйлд хяналт тогтоох, 26.4 дүгээр зүйлд ажиглалт явуулах, 27.10 дугаар зүйлд хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах талаар тус тус зохицуулжээ. Эдгээр ажиллагааг явуулах хангалттай үндэслэл байгаа талаар мөрдөгч санал гаргаж, прокурорын зөвшөөрлийг авна. Ажиллагааны явцад хүний эрхийг хангах арга хэмжээний талаар прокурорын зөвшөөрөлд заахаар тусгасан.</p> <p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24.3 дугаар зүйлд /Орон байр, бусад газарт нэгжлэг хийх/ мөрдөгч орон байр, бусад газарт прокурорын зөвшөөрлөөр нэгжлэг хийхэд тухайн газарт нэвтрэх, эсхүл түгжээтэй зүйлийг нээх, шаардлагатай бол хана, тааз болон шалыг салгах, задлах зэрэг ажиллагаа явуулж болох бөгөөд тийнхүү нэгжлэг хийсний дараа салгасан, задалсан эд зүйлийг өмнөх хэвд нь оруулах буюу сэргээх талаар заагаагүй.</p>
-----------	--	-------------	--	---



			<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд бүх төрлийн хэрэг дээр хүний биед үзлэг хийх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах, харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох, хяналт тогтоох, нууц ажиглалт явуулахаар заасан байна. Тодорхой төрлийн буюу зөвхөн хүнд гэмт хэргээр хязгаарлаж хүний биед үзлэг хийж болох, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах, харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох, хяналт тогтоох, нууц ажиглалт явуулах талаар нарийвчлан зааглах шаардлагатай байна.</p> <p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-т зааснаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай мөрдөгчийн саналд ажиллагаа явуулах зорилгоос гадна үндэслэлийг тусгах шаардлагатай. Гэвч, “Хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах тухай мөрдөгчийн санал /МША-73/” баримт бичгийн загварт авах дээжийн хэмжээ, тийнхүү дээж авах хангалттай үндэслэл, ямар шинжээч, эсхүл мэргэжилтний тусламжтайгаар явуулах талаар тусгаагүй орхисон байна.</p> <p>Эндээс үзэхэд, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалттай холбоотойгоор Улсын Ерөнхий прокурорын 2017 оны А/59 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан прокурор болон мөрдөгчөөс гаргах эрх зүйн актын загвар ерөнхий байдалтай байх бөгөөд түүний нөхөж бичих хэсэгт нарийвчилсан утгыг бичих шаардлага бага байгаа нь халдашгүй байх эрхэд халдах шийдвэр гаргахад алдаа гаргах эрсдэлийг бий болгож байна.</p> <p>Улсын Их Хурлаас 2020.01.10-ны өдөр нэмэлт оруулсан Эрүүгийн хуулийн 21.13 дугаар зүйлийн 2-т “Гүйцэтгэх ажил явуулах эрхгүй этгээд гүйцэтгэх ажлын тусгай</p>
--	--	--	---

				<p>техник олж авсан, ашигласан, борлуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэсэн хэсэг, Гүйцэтгэх ажлын тухай хуульд 2015.07.09-ний өдрийн хуулиар шинээр нэмсэн 6.3 дахь хэсэг буюу “Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэж ... илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ” гэсэн зохицуулалт нь иргэн, сэтгүүлчид тагнаж чагнуулахаас өөрийгөө хамгаалах багаж, хэрэгсэлтэй байхыг хориглосон байна.</p>
H2	<p>Хуульд хүний хувийн нууц, гэр бүл, орон гэр, захидал харилцаанд хөндлөнгөөс оролцох эрх бүхий байгууллагуудын нэрийг тодорхой зааж өгсөн үү?</p>	Тийм	<p>Хувийн нууцыг хамгаалах эрхэд хөндлөнгөөс оролцож болох эрх бүхий байгууллагуудыг хуулиар тодорхой зааж өгөх ёстой.</p> <p>НҮБ-ын Хүний эрхийн хорооны Ерөнхий тайлбар №16, 8-р хэсэг</p>	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хүний халдашгүй байх эрхэд халдахад чиглэсэн ажиллагааг зохицуулсан. Тодруулбал, хүний биед үзлэг хийх, нэгжлэг хийх, хүний биед нэгжлэг хийх, орон байр, бусад газарт нэгжлэг хийх, эд мөрийн баримт хураан авах, мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах, харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох, ажиглалт явуулах, хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах ажиллагааг явуулах хангалттай үндэслэл байгаа талаар мөрдөгч санал гаргаж, прокурорын зөвшөөрлийг авна.</p> <p>Эрүүгийн хуулийн 13 дугаар бүлэг буюу “Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг”, 13.7 дугаар зүйл буюу “Хууль бусаар нэгжих, хураан авах, битүүмжлэх” гэмт хэрэгт хууль бусаар хүний биед үзлэг хийхийг хамруулаагүй байна. Харин Эрүүгийн хуулийн 13.12 дугаар зүйл /Хууль бусаар мөрдөж мөшгөх/-ийн 2-т эрх бүхий албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хууль зөрчиж мөрдөн шалгах ажиллагаа явуулсан, хувийн зорилгоор албаны техник</p>

				хэрэгслийг ашиглан бусдыг мөрдөж мөшгөсөн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэж заасан.
Н3	Холбогдох байгууллагууд хүний хувийн нууц, гэр бүл, орон гэр, захидал харилцаанд хөндлөнгөөс оролцож болох нөхцөл байдлыг хуульд тодорхой зааж өгсөн үү?	Тийм	<p>Хууль тогтоомжид холбогдох байгууллагууд тухайн хүний хувийн нууц, гэр бүл, орон гэр, захидал харилцаанд ямар нөхцөлд хөндлөнгөөс оролцож болох тухай нарийвчлан зааж өгөх ёстой.</p> <p>НҮБ-ын Хүний эрхийн хорооны Ерөнхий тайлбар №16, 8-р хэсэг.</p>	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хүний биед үзлэг хийх, нэгжлэг хийх, хүний биед нэгжлэг хийх, орон байр, бусад газарт нэгжлэг хийх, эд мөрийн баримт хураан авах, мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах, харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох, ажиглалт явуулах, хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах ажиллагааг явуулах хангалттай үндэслэл байгаа талаар мөрдөгч санал гаргаж, прокурорын зөвшөөрлийг авна. Ингэхдээ дараах зорилго, үндэслэлийг холбогдох шийдвэрт тусгана:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүний биед хэргийн үл мөр, онцлог шинж тэмдэг байгаа, эсхүл хэрэгт ач холбогдол бүхий эд зүйл, баримт бичгийг тухайн хүн биедээ авч яваа гэх үндэслэл бүхий сэжиг байгаа бол түүнийг илрүүлэх зорилгоор хүний биед үзлэг хийх</li> <li>- Хэргийн эд мөрийн баримт, бичмэл нотлох баримт, эсхүл эрэн сурвалжилж байгаа хүн, эд зүйл байна гэх хангалттай үндэслэл байвал тэдгээрийг илрүүлэх; хэрэг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий зүйлийг биедээ нууж байна гэх хангалттай үндэслэл байвал түүнийг илрүүлэх зорилгоор нэгжлэг хийх, хүний биед нэгжлэг хийх, хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах, орон байр, бусад газарт нэгжлэг хийх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох, хяналт тогтоох, ажиглалт явуулах.</li> </ul>
Н4	Хүний хувийн халдашгүй байх эрх зөрчигдсөн тухай гомдол	Тийм	Хүүхдийн бэлгийн хүчирхийллийн шинжтэй	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.1 дүгээр зүйлийн 8-д зааснаар үзлэгийг нууцаар хийх бол

<p>гаргах механизмыг хуулиар баталгаажуулсан уу?</p>		<p>зураг, хувийн эмзэг зургийг зөвшөөрөлгүй бусадтай хуваалцах гэх мэт хувийн мэдээллийг түгээх замаар хувь хүнд хор хохирол учруулах нь хуулиар шийтгэгдэх гэмт хэрэгт тооцогдох ёстой. Хувийн нууцыг нь зөрчиж, хувийн мэдээллийг хууль бусаар ашигласан тохиолдолд хүн бүр хуулийн арга хэмжээ авах боломжтой байх ёстой. Хувийн мэдээлэл, харилцаа холбоог хамгаалах хяналтын механизмыг бие даасан байгууллагын хэлбэрээр хуульчлан байгуулж, уг байгууллагад хүний эрх, хувийн нууцыг хамгаалах чиглэлийн мэргэжлийн хүмүүсийг ажиллуулах нь зүйтэй. АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 42(6)-(8).</p>	<p>оролцох хүнд энэ хуульд заасан эрх, үүргийг тайлбарлах, эрхээ эдлэх боломжоор хангах зохицуулалт хамаарахгүй. 15.7 дугаар зүйлийн 1-т зааснаар оролцогч нь мөрдөгчийн шийдвэр, ажиллагаанд гаргах гомдлыг хяналт тавьж байгаа прокурорт, хяналт тавьж байгаа прокурорын шийдвэр, ажиллагааны талаарх гомдлыг тухайн нэгжийн дээд шатны прокурорт шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор гаргана. Эрүүгийн хуулийн 13 дугаар бүлэгт “Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг”-ийг тусгасан. Тодруулбал, 13.6 дугаар зүйлд “Бусдын орон байранд хууль бусаар нэвтрэн орох”, 13.7 дугаар зүйлд “Хууль бусаар нэгжих, хураан авах, битүүмжлэх”, 13.8 дугаар зүйлд “Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах”, 13.9 дүгээр зүйлд “Хууль бусаар баривчлах, саатуулах”, 13.10 дугаар зүйлд “Хувь хүний нууцад халдах”, 13.11 дүгээр зүйлд “Хувь хүний нууцыг задруулах”, 13.12 дугаар зүйлд “Хууль бусаар мөрдөж мөшгөх” гэмт хэргийг зохицуулсан. Эрүүгийн хуулийн 13.7 дугаар зүйлд хууль бусаар хүний биед үзлэг хийхийг хамруулаагүй байна. Харин Эрүүгийн хуулийн 13.12 дугаар зүйлийн 2-т эрх бүхий албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хууль зөрчиж мөрдөн шалгах ажиллагаа явуулсан, хувийн зорилгоор албаны техник хэрэгслийг ашиглан бусдыг мөрдөж мөшгөсөн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэж заасан. Эдгээр гэмт хэрэг үйлдсэн талаар гомдол гаргах эрхтэй. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 20.1-т зааснаар Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө зөрчсөн талаар Монгол Улсын иргэн</p>
--	--	---	---

				дангаар, эсхүл хамтарч энэ хуульд заасны дагуу гомдол, мэдээлэл гаргах эрхтэй. Мөн 20.2-т зааснаар Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын иргэний нэгэн адил гомдол, мэдээлэл гаргах эрх эдэлнэ. 20.3-т зааснаар хүүхэд болон иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй, зарим, эсхүл бүрэн бус чадамжтай хүн өөрт хамаарах аливаа асуудлаар бие даан, эсхүл тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээрээ дамжуулан гомдол, мэдээлэл гаргаж болно. Тус хуулийн 26.1.1-т зааснаар хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн, зөрчих нөхцөл бүрдүүлсэн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд Комиссын гишүүн шаардлага, зөвлөмж хүргүүлнэ.
H5	<p>Хувийн захидал, харилцааг тагнаж, чагнахыг зөвхөн дараах тохиолдолд зөвшөөрөх тухай хуулийн заалт бий юу?</p> <p>1) хуулиар зөвшөөрөгдсөн, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн, үйлдэгдэж байгаа гэсэн тодорхой, үндэслэлтэй хардлагад үндэслэсэн байх,</p> <p>2) өөр хууль ёсны зорилгоор зохион байгуулж буй.</p> <p>“Хууль ёсны зорилго” гэж хүний үндсэн эрхийг хязгаарлах олон улсын эрх зүйд заасан зөвшөөрөгдөх зорилгыг хэлнэ. Тухайлбал: бусдын эрх, нэр хүндийг хамгаалах, үндэсний</p>	Үгүй	<p>Төрөөс зөвхөн тодорхой зорилгын хүрээнд, дараах шалгуурыг хангаж, харилцаа холбооны зорилтот тагнах үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрнө:</p> <p>1. олон улсын хүний эрхийн хууль тогтоомж, стандартад нийцсэн, онц ноцтой гэмт хэрэг үйлдсэн гэсэн тодорхой бөгөөд үндэслэл бүхий сэжигтэй, хуулиар зөвшөөрөгдсөн, эсхүл 2. хэрэгжиж байгаа болон бусад хууль ёсны зорилгоор.</p> <p>АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 41(2).</p>	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26.2 дугаар зүйлд “Харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох”, 26.4 дүгээр зүйлд “Ажиглалт явуулах” нөхцөлийг тусгасан. Ингэхдээ хэрэгт ач холбогдол бүхий мэдээ, баримтыг цуглуулах, бэхжүүлэх зорилгоор тус ажиллагааг явуулах талаар заасан. Энд тухайн ажиллагааг явуулахад хэргийн төрөл нь хүнд, ноцтой хэрэг байх шаардлага тавиагүй. Тодруулбал, харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох, нууц ажиглалт явуулах нь бүх төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгахад хамаарч байна. Хүнд гэмт хэрэг буюу цөөн гэмт хэрэгт дээрх ажиллагааг явуулах талаар хуульд нарийвчлан заагаагүй. Ажиллагаа явуулах хугацааны талаар тусгайлан заагаагүй бөгөөд зөвхөн прокурорын зөвшөөрөлд ажиллагаа явуулах хугацааны талаар заахаар тусгасан байна.</p>

	<p>аюулгүй байдал, нийтийн хэв журам, нийтийн аюулгүй байдлыг хамгаалах</p>		<p>Тайлбар: Цахим харилцаа холбооны “бүх нийтийг хамарсан” буюу “зорилтот бус” тагнах чагнах үйл ажиллагааг олон улсын эрх зүйн хүрээнд хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэх нь улам бүр нэмэгдэж байна. Олон нийтийг тагнаж чагнах нь хүний эрхийг хамгаалахад үл нийцэх тухай шинээр гарч ирж буй стандартыг С-293/12 ба С-594/12-ын нэгдсэн хэргийн талаарх Европын Холбооны Шүүхийн шийдвэрээс харна уу.</p>	
Н6	<p>Тагнах, чагнах үйл ажиллагааг бүх нийтийг хамарсан, зорилтот бус хэлбэрээр зохион байгуулахыг хуулиар зөвшөөрдөг үү? “Олон нийтийн” буюу “зорилтот бус” тагнах үйл ажиллагаа гэж тодорхой бус, олон тооны хүний тухай мэдээлэл үүсгэх, цуглуулах, дүн шинжилгээ хийхийг хэлнэ.</p>	Тийм	<p>Төрөөс тодорхойгүй, олон тооны хүний хувийн харилцааны мэдээллийг хадгалах, дүн шинжилгээ хийх, бусдад дамжуулахыг хуваалцах үйл ажиллагааг зохион байгуулах, ийм ажиллагааг хүлээн зөвшөөрөх ёсгүй. АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 41(1). Мөн Н5 дугаар асуулттай холбоотой тайлбарыг үзнэ үү.</p>	<p>Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 13.12 дугаар зүйл /Хууль бусаар мөрдөж мөшгөх/-ийн 1-т “Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшгөсөн бол”, 2-т “Эрх бүхий албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хууль зөрчиж мөрдөн шалгах ажиллагаа явуулсан, хувийн зорилгоор албаны техник хэрэгслийг ашиглан бусдыг мөрдөж мөшгөсөн бол”, 21.13 дугаар зүйл /Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих/-ийн 1-т “Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь гүйцэтгэх ажлын тухай хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан бол”, 2-т “Гүйцэтгэх ажил явуулах эрхгүй этгээд гүйцэтгэх ажил явуулсан бол” тус тус эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан.</p>

				<p>Эдгээр заалт нь олноор эсвэл товлож тагнах, чагнах, мөрдөн мөшгөх ажиллагаа явуулахыг хуулиар зөвшөөрөөгүй болохыг харуулж байна. Гэвч, олон нийтийн хувьд тэднийг тагнаж, чагнах, мөрдөн мөшгөхөөс өөрийгөө хамгаалахыг хориглосон. Улсын Их Хурлаас 2020.01.10-ны өдөр нэмэлт оруулсан Эрүүгийн хуулийн 21.13 дугаар зүйлийн 2-т “Гүйцэтгэх ажил явуулах эрхгүй этгээд гүйцэтгэх ажлын тусгай техник олж авсан, ашигласан, борлуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэсэн хэсэг, Гүйцэтгэх ажлын тухай хуульд 2015.07.09-ний өдрийн хуулиар шинээр нэмсэн 6.3 дахь хэсэг буюу “Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэж ... илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ” гэсэн зохицуулалт нь иргэн, сэтгүүлчид тагнаж чагнуулахаас өөрийгөө хамгаалах багаж, хэрэгсэлтэй байхыг хориглосон байна.</p> <p>Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 27.8-д зааснаар Хүний эрхийн Үндэсний Комисс дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн системийг хууль ёсны дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор хууль хяналтын байгууллагатай хамтран шалгалт хийж болно.</p>
--	--	--	--	--

## I. ХУВИЙН ӨГӨГДӨЛ ХАМГААЛАХ

11	Хувийн өгөгдлийг тусгайлан хамгаалдаг хууль (жишээ нь, Өгөгдөл хамгаалах тухай хууль) байдаг уу?	Тийм	Төрөөс хувийн нууцыг хамгаалах эрх зүйн баталгааг хангах ёстой.	Улсын Их Хурал 2021.12.17-ны өдөр Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль баталсан. Энэ хуулийг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Энэ хуулиар хүний хувийн мэдээллийг
----	--	------	---	--

	“Хувийн өгөгдөл” гэдэг нь биометрийн мэдээлэл зэрэг тухайн хүнийг шууд болон шууд бусаар таних боломжийг бусдад олгодог аливаа мэдээллийг хэлнэ.		АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 41(3). Мөн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 75/176 тоот шийдвэрийг үзнэ үү.	цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулна. Тус хуулийн 4.1.11-т зааснаар “хүний хувийн мэдээлэл” гэж хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг ойлгоно.
12	Хувийн өгөгдлийг боловсруулах эрх бүхий байгууллагыг хуулиар тодорхойлж өгсөн үү? “Боловсруулах” гэж хувь хүний мэдээллийг цуглуулж, ангилах, тайлбарлах зэргээр утга учиртай	Тийм	Хувийн өгөгдөлтэй ажиллах үйл ажиллагааны шинж чанар, хамрах хүрээ, үргэлжлэх хугацаа, энэхүү үйл ажиллагааг удирдах, хянах эрх мэдэл бүхий байгууллагатай холбоотой хэм хэмжээг хуулиар зохицуулах ёстой. А/HRC/23/40, 81-р хэсэг. Мөн АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 41(3)-г үзнэ үү.	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.8-т зааснаар, хуульд заасны дагуу, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлийн дагуу мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг “мэдээлэл хариуцагч” гэнэ. Тус хуулийн 6 дугаар зүйлд төрийн байгууллага мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, 7 дугаар зүйлд хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах нөхцөлийг тусгасан. Мөн хуулийн 24-26 дугаар зүйлд мэдээлэл хамгаалах талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын бүрэн эрх, цахим орчинд мэдээлэл хамгаалах талаарх цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, мэдээлэл хамгаалах талаарх төрийн бусад байгууллагын бүрэн эрхийг заасан.
13	Эрх бүхий холбогдох байгууллага хувийн өгөгдлийг ямар зорилгоор боловсруулж болохыг хуулиар тодорхой зааж өгсөн үү?	Тийм	Хуульд эрх бүхий байгууллага хувийн мэдээллийг ямар зорилгоор боловсруулахыг тодорхой зааж өгөх ёстой.	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 6.1-т зааснаар төрийн байгууллага дараах тохиолдолд мэдээлэл цуглуулж, боловсруулна: 6.1.1. мэдээллийн эзний зөвшөөрлөөр; 6.1.2. хуульд заасан үндэслэлээр;



			<p>12 дугаар асуулттай холбоотой удирдамжийг үзнэ үү</p>	<p>6.1.3. хуульд заасан тохиолдолд хөдөлмөрийн харилцааны явцад мэдээлэл хариуцагч эрхээ эдлэх, үүргээ биелүүлэх;</p> <p>6.1.4. гэрээ байгуулах, байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах;</p> <p>6.1.5. Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;</p> <p>6.1.6. мэдээллийн эзний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүйгээр хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх.</p> <p>Мөн хуулийн 6.2-т зааснаар төрийн байгууллага дараах тохиолдолд мэдээллийг ашиглана:</p> <p>6.2.1. мэдээллийн эзний зөвшөөрлөөр;</p> <p>6.2.2. хуульд заасан үндэслэлээр;</p> <p>6.2.3. мэдээллийн эзний амь нас, бие махбод, эрх, эрх чөлөө, эд хөрөнгөд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх, түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;</p> <p>6.2.4. бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх;</p> <p>6.2.5. хүнийг тодорхойлох боломжгүй болгож түүх, эрдэм шинжилгээ, урлаг, утга зохиолын бүтээл туурвих, статистикийн мэдээлэл бэлтгэх.</p> <p>Хуулийн 7.1-т зааснаар төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, хүн дараах тохиолдолд мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглана:</p> <p>7.1.1.энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.4-т заасан үндэслэлээр;</p> <p>7.1.2.хуульд заасны дагуу нийтэд ил болгосон;</p> <p>7.1.3.хүнийг тодорхойлох боломжгүй болгож түүх, эрдэм шинжилгээ, урлаг, утга зохиолын бүтээл туурвих, нээлттэй өгөгдөл, статистикийн мэдээлэл бэлтгэх.</p>
--	--	--	--	---

14	Хуульд хувийн мэдээллийг хэр удаан хугацаанд хадгалах талаар тодорхой зааж өгсөн үү?	Тийм	Өгөгдөлтэй танилцах, дүн шинжилгээ хийх, эсвэл бусад хэрэглээг тодорхой зорилгын хүрээнд хязгаарлах ёстой. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Бүлгийн Өгөгдлийн нууцлал, ёс зүй ба хамгаалалт: 2030 он хүртэлх мөрийн хөтөлбөрт хүрэх өгөгдлийн талаарх удирдамж.	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.7, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 4.1.5-д зааснаар мэдээллийг ангилах, хадгалах, дүн шинжилгээ хийх, өөрчлөх, устгах, сэргээх үйл ажиллагаа, тэдгээрийн нийлбэрийг “мэдээлэл боловсруулах” гэнэ. Тодруулбал, хүний хувийн мэдээллийг хадгалах нь түүнийг боловсруулах үйл ажиллагаанд хамаарна. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 8.2.4-т зааснаар мэдээлэл хариуцагч нь мэдээллийн эзэнд мэдээлэл боловсруулах, ашиглах хугацааны нөхцөлийг танилцуулж, зөвшөөрөл авна. Хуулийн 8.3-т зааснаар мэдээллийн эзэн зөвшөөрлийг мэдээлэл хариуцагчид бичгээр өгөх бөгөөд энэ зөвшөөрөл нь цаасан, эсхүл цахим хэлбэртэй байна. Хуулийн 8.7-д зааснаар мэдээллийн эзэн өгсөн зөвшөөрлөө хэдийд ч цуцалж болох бөгөөд цуцлах тухай хүсэлтийг хүлээн авснаас өмнөх хугацаанд хийгдсэн мэдээлэл боловсруулалт нь энэ хуулийг зөрчөөгүй бол хууль ёсны хэвээр үлдэнэ.
15	Хуулиар хүн бүр өөрийнх нь талаар ямар хувийн мэдээлэл, ямар зорилгоор хадгалагдаж байгааг олж мэдэх эрхийг баталгаажуулсан үү?	Тийм	Хүн бүр өөрийнх нь тухай өгөгдлийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй байх, мэдээлэл авах эрхийг хуулиар хамгаална. АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 42(3).	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлд мэдээллийн эзний эрхийг заасан. Тодруулбал, тус хуулийн 16.1.3-т зааснаар энэ хуулийн 8.2-т заасан мэдээллийг мэдэх эрхтэй. Хуулийн 8.2 буюу мэдээлэл хариуцагч мэдээллийн эзэнд танилцуулж, зөвшөөрөл авах нөхцөлд мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үндэслэл, зорилго; цуглуулах, боловсруулах, ашиглах мэдээллийн жагсаалт багтсан.
16	Хуулийн заалтыг зөрчиж, буруу мэдээлэл цуглуулсан, боловсруулсан тохиолдолд тухайн хүн тухайн мэдээллийг засварлах, бүрэн дүүрэн болгох,	Тийм	Хүн бүр буруу, бүрэн бус, эсхүл хууль бусаар цуглуулсан, ашигласан, задруулсан, хадгалсан хувийн мэдээллийг	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 16.1.5-д зааснаар мэдээллийн эзэн нь алдаатай мэдээллийг залруулах талаар мэдээлэл хариуцагчид мэдэгдэж өөрчлөлт оруулах, нэмэлт мэдээлэл өгч тусгуулах; 16.1.6-д зааснаар хуульд заасны дагуу

	устгах хүсэлт гаргах эрхтэйг хуульчилсан уу?		засах, бөглөх, устгах боломжтой байх ёстой. АХБАТЭ ТУНХАГЛАЛЫН ЗАРЧИМ 42(3)(d).	өөрийн мэдээллийг устгуулах талаар мэдээлэл хариуцагчид мэдэгдэж устгуулах; 16.1.7-д зааснаар мэдээллийг хууль тогтоомжийн дагуу цуглуулахыг хориглосон, устгахаар заасан бол хэрэгжүүлэхийг шаардах эрхтэй. Мөн хуулийн 29.1-т зааснаар мэдээллийн эзнээс хуульд заасан үндэслэл болон анх зөвшөөрөл авснаас өөр зорилгоор мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахыг хориглоно, 29.2-т зааснаар мэдээллийг хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулсны үр дүнд мэдээллийн эзний эрх, эрх чөлөөг зөрчихийг хориглоно, 29.3-т зааснаар мэдээллийг энэ хуульд заасны дагуу олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглоно.
--	--	--	---	--